



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (150)

**Монгол Улсын Засгийн газрын 2000 оны
24 дүгээр тогтоолын хавсралт:**

- *Монгол Улсын Төрийн ёслолын журам*

Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол:

- *Далнуурлын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг,
заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

**Улаанбаатар хот
2000 он**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны дөрөвдүгээр сарын 17

№13 (150)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

163. Засгийн газрын 2000 оны 24 дүгээр тогтоолын хавсралт
"Монгол Улсын Төрийн ёслолын журам"

287

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

164. Дампуурлын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг,
заалтыг тайлбарлах тухай

Дугаар 01

308

*Монгол Улсын Засгийн газрын 2000
оны 24 дүгээр тогтоолын хавсралт*

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЁСЛОЛЫН ЖУРАМ

(Турүүч нь №12-т гарсан)

Арав. Оршуулгын журам

10.1. Төр, засгийн удирдагч таалал төгсөхөд

10.1.1. УИХ, Засгийн газраас төр, засгийн удирдагч таалал төгссөн тухай гүн эмгэнэлтэйгээр мэдэгдэж талийгаачийн зураг, намтрыг хэвлэлд нийтлүүлж Улаанбаатар дахь дипломат корпуст ноотоор мэдээлнэ.

10.1.2. Засгийн газраас талийгаачийг оршуулах ажлыг зохион байгуулах комисс томилох бөгөөд уг комисс орон даяар гашуудал зарлах өдрүүдийг тогтооно (Ерөнхийлөгч таалал төгсөхөд 5-7 хоног, УИХ-ын дарга буюу Ерөнхий сайд таалал төгсөхөд 3-5 хоног). Талийгаачийн шарилыг хаана байрлуулж ямар хугацаанд салах ёс гүйцэтгэх, хэзээ хаана оршуулахыг шийдвэрлэж зарлана.

10.1.3. Төрийн далбааг гашуудлын өдрүүдэд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулган эмгэнэл илэрхийлнэ. Орон даяар урлагийн тоглолт, кино зэрэг цэнгэлийн үйл ажиллагаа явуулах, ёслолын арга хэмжээ зохиохыг хориглоно.

10.1.4. Найрсаг харилцаат орнуудаас төлөөлөгч ирж оршуулах ёслолд оролцох асуудал тавибал комисс шийдвэрлэж хариу өгнө. УИХ-ын дарга буюу Ерөнхий сайд таалал төгсөхөд гадаадаас төлөөлөгч урихгүй.

0.2. Салах ёс гүйцэтгэх

10.2.1. Салах ёс гүйцэтгэх танхимын гадаа гол хаалган дээр талийгаачийн томоор зурсан хөргийг байрлуулна. Танхимын цонх, чийдэнг эмгэнэлийн байдлаар бүдгэрүүлэн бүтээж, ногоон шилмүүсээр чимэглэнэ.

10.2.2. Шарилыг танхимын хоймор талд тусгай зассан тавцан дээр байрлуулж, сагстай амьд цэцэг тойруулан тавина. Танхимд байнга арц, хүж асаана. Шарилыг төрийн хүндэт харуулын 8 цэрэг хүндэтгэн хамгаалж зогсоно.

10.2.3. Авсны тагийг тэнгэрийн өнгөт хөх цэнхэр, хайрцгийг дэлхийн өнгөт ногоон торгоор доторлож, гадна талыг цагаан торгоор бүрсэн байна. Авсыг алтан саатай шар бүсээр гурав бүсэлсэн байдлаар бэхлэхээр бэлтгэнэ.

10.2.4. Талийгаачийн жаазтай том зургийг шарилын толгой талд тусгай бүрээстэй өндөр тавцан дээр байрлуулж хадгаар бүтээн, жаазны зүүн доод өнцгийг хар, улаан даавуугаар чагтална. Зургийн баруун талд төрийн далбааг бөхийлгөн зална.

10.2.5. Салах ёс гүйцэтгэх ёслол эхэлмэгц эхлээд талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсөд, дараа нь комиссын гишүүд, төр, засгийн удирдагчид дараалан тус бүр 3 минутаар шарилын дэргэд толгой гудайн зогсоно.

10.2.6. Салах ёс гүйцэтгэхээр хүрэлцэн ирсэн хүмүүс комиссын зохион байгуулснаар салах ёс гүйцэтгэнэ.



10.2.7. Салах ёс гүйцэтгэх ёслол эхлэхээс дуусах хүртэл хөгжим гашуудлын аялгуу эгшиглүүлж байна.

10.3. Оршуулах

10.3.1. Шарилыг танхимаас гаргахын өмнө төр, засгийн удирдагчид, дараа нь комиссын гишүүд, талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсөд эцсийн удаа хүндэтгэл үзүүлж зогсоно.

10.3.2. Шарилыг танхимаас гаргахдаа босгон дээр нь хөндлөн мод тавьж, шарилаа толгой талаар нь гаргаж шарил ачих машинд дэвссэн цагаан эсгийн дээр толгойг нь явах зүг рүү харуулж зална.

10.3.3. Гашуудлын цуваа оршуулах газрын зүг алгуурхан хөдөлнө. Цувааг талийгаачийн зураг, албан байгууллага, хүмүүсээс тавьсан цэцэг, авсны таг, шарил, комиссын гишүүд, төр, засгийн удирдагчид, талийгаачийн гэр бүл, төрөл, төрөгсөд болон ёслолд оролцогчид гэсэн дарааллаар хөдөлгөнө. Цувааг үлээвэр найрал хөгжим дагалдан явж гашуудлын аялгуу эгшиглүүлнэ.

10.3.4. Оршуулах талбайд ирж, шарилыг машинаас буулган нүхний баруун талд дэвссэн цагаан эсгий дээр зассан суурь дээр байрлуулна. Талийгаачийн зураг болон тавьсан цэцгийг шарилын баруун, зүүн талд нь барьж зогсоно. Төр, засгийн удирдагчид, комиссын гишүүд болон оршуулах ёслолд оролцогчид байраа эзэлнэ.

10.3.5. Талийгаачийг оршуулах ажлыг зохион байгуулах комиссын дарга үг хэлж гашуудлын цуглааныг нээнэ. Цуглаан дээр үүргийг гүйцэтгэгч, гэр бүл, төрөл төрөгсдийг төлөөлж нэг хүн, иргэдийг төлөөлж нэг хүн тус тус үг хэлнэ. Комиссын дарга цуглааныг хаана, хөгжимд гашуудлын аялгуу эгшиглэнэ.

10.3.6. Гэр бүл, төрөл төрөгсөд нь эцсийн удаа салах ёс гүйцэтгэнэ (энэ үед хөгжим зогсоно). Авсны тагийг хааж бэхэлнэ (хөгжимд гашуудлын аялгуу эгшиглэнэ). Шарилыг өргөн нүх рүү хийж, эх газрын алтан хөрсөнд далдална. Энэ үед хөгжим зогсож их буугаар ёслолын буудлага хийнэ (Ерөнхийлөгч таалал төгсөхөд 21 удаа, УИХ-ын дарга буюу Ерөнхий сайд таалал төгсөхөд 19 удаа). Хөгжимд төрийн дуулал эгшиглэнэ. Төв, орон нутагт бөхийлгөсөн төрийн далбаануудыг хэвийн байдлаар мандуулна.

10.3.7. Дараа нь Засгийн газраас гашуудал тайлах цагаалга хийнэ. Цагаалга дээр үүрэг гүйцэтгэгч үг хэлж гашуудал тайлна.

10.3.8. Оршуулах ёслолд гадаадын төлөөлөгчид ирвэл тэднийг ямар нэгэн ёслолгүйгээр унтаж, үднэ.

10.4. Тус улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд

10.4.1. Төр, засгийн удирдагч таалал төгссөн тухай мэдээ авмагц суугаа орны Гадаад хэргийн яам болон тэнд суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газруудад ноотоор мэдээлнэ. Ноот нь ёслол хүндэтгэлийн үггүй байх бөгөөд дипломат төлөөлөгчийн газарт эмгэнэл илэрхийлэх цагийг заана.

10.4.2. Талийгаачийн том хэмжээний гэрэл зургийг жаазлан, жаазны зүүн доод өнцгийг хар, улаан даавуугаар чатглан гашуудлын байдлаар бэлтгэн тусгай танхимд зассан өндөр тавиур дээр байрлуулж, эргэн тойрон амьд цэцгээр чимэглэнэ. Зургийн баруун талд төрийн далбааг бөхийлгөн зална. Танхимд эмгэнэлийн дэвтэр бэлтгэж, ширээн дээр тавина.

10.4.3. Суугаа орны удирдагчид болон хөдөлмөрчдийн төлөөлөгчид, дипломат корпусаас эмгэнэл илэрхийлэхээр ирэхэд нь дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн дипломатуудын хамт хүлээн авч, явахад нь талархал илэрхийлж байна.

10.4.4. Дипломат төлөөлөгчийн газрын албан байр дээр төрийн далбааг гашуудлын өдрүүдэд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулган эмгэнэл илэрхийлнэ.

10.5. Төрийн өндөр албан тушаалтан таалал төгсөхөд

10.5.1. Эмгэнэлийн бичигт төр, засгийн удирдагчид болон УИХ, Засгийн газрын холбогдох гишүүд гарын үсэг зурж хэвлэлд нийтлүүлнэ.

10.5.2. Салах ёс гүйцэтгэх, оршуулахдаа энэхүү журмын 10.2.4-10.2.7 болон 10.3.1-10.3.5-д заасныг жишиг болгоно. Гэхдээ орон даяар гашуудал зарлахгүй, төрийн далбааг бөхийлгөх буюу буулгахгүй, шарил байрлуулсан байрны гадна талд талийгаачийн хөрөг зургийг байрлуулахгүй, оршуулгын газар төрийн дуулал эгшиглүүлэх боловч ёслолын буудлага хийхгүй.

10.6.1. Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, төрийн шагналтан, ардын цолтны эмгэнэлийн бичигт төр, засгийн удирдагчид болон УИХ, Засгийн газрын холбогдох гишүүд гарын үсэг зурж хэвлэлд нийтэлнэ.

10.6.2. Гавъяат цолтны эмгэнэлийн бичигт Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон УИХ, Засгийн газрын холбогдох гишүүд гарын үсэг зурж хэвлэлд нийтэлнэ.

10.6.3. ТӨ-1, ТӨ-П-т хамаарах албан тушаал хашиж явсан төрийн зүтгэлтэн таалал төгсөхөд энэхүү журмын 10.5.2-т заасныг мөрдөнө.

10.6.4. Төрийн ёслолын алба төр, засгийн



уидрдагчид гарын үсэг зурах эмгэнэлийн бичгийг нийтлэх, мэдээлэх зөвшөөрлийг олгоно.

ХАВСРАЛТ.

/Энэ хуульд 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар орсон хэлэлт, өөрчлөлтийг тусгасан болно/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журам болон Төрийн дууллыг хуульчлан бататгахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдэг

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал /цаашид "Төрийн бэлгэ тэмдэг" гэх/ мөн.

2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль тогтоомж

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн сүлд, түүнийг үйлдэх, дүрслэх, байрлуулах

4 дүгээр зүйл. Төрийн сүлд

Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугираг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч

чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

5 дугаар зүйл. Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэх

1. Төрийн сүлдийг өнгө ялгах буюу ялгахгүйгээр үйлдэж дүрсэлж болно.

2. Төрийн сүлдийг өнгө ялган үйлдэх буюу дүрслэхэд соёмбо, эрдэнийн хүлэг, түмэн насан хээ, хүрд нь алтан шар, тэнгэр нь хөх, уулан хээ нь тодоос шингэрээж гурваар дагнасан ногоон, бадам цэцэг нь алтан шар өнгийн хүрээтэй цагаан, хадаг нь алтан шар утсаар хүрээлсэн цэнхэр, чандмань эрдэнэ нь ногоон, улаан, хөх өнгийг дөрвөөр дагнаж алтан шар өнгийн зураасаар хүрээлсэн байна. Төрийн сүлдний чандмань эрдэнэ, түмэн насан хээ, бадам цэцэг нь элгэн хүрэн дэвсгэр дээр байрлана.

3. Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, харьцааг чанд баримтална.

6 дугаар зүйл. Төрийн сүлдийг байрлуулах

1. Төрийн сүлдийг:

1/Монгол Улсын Төрийн тамганд;

2/Монгол Улсын хилийн багананд;

3/Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын хайрцаг дээр;

4/Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэцийн хуралдааны болон Төрийн ордны соёмбот танхим, Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөө, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн даргын албан тасалгаанд;

5/Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын хуралдааны байранд-хуралдааны хугацаанд;

6/Бүх шатны шүүхийн шүүх хуралдааны болон иргэдийн төрөлт, гэрлэлтийг бүртгэх танхимд;

7/Бүх шатны Засаг даргын албан тасалгаанд;

8/Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газар, иргэдийн



Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын Тэргүүлэгчид, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хаягт;

9/Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн хурал, бүх шатны Засаг дарга, шүүх, прокурор, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хэвлэмэл хуудаст;

10/галт тэрэгний зүтгүүр, суудлын вагоны хажуу талд тус тус байрлуулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан танхим, өргөө, албан тасалгаанд байрлуулах Төрийн сүлдийг өнгөөр ялгасан байна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад газарт Төрийн сүлдийг байрлуулах асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн туг, түүнийг үйлдэх, байрлуулах, хүндэтгэн залах

7 дугаар зүйл. Төрийн туг

1.Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

2.Есөн хөлт Их цагаан туг нь Монгол Улсын Төрийн туг мөн.

8 дугаар зүйл. Төрийн тугийг үйлдэх

1.Төрийн тугийг Монгол Улсын бүх аймгийн адуун сүргийн дотроос шилж сонгосон цагаан зүсмийн азарганы 80,0 см-ээс доошгүй урттай, дэл сүүлээр, ганц хувь үйлдэнэ.

2.Их цагаан тугны нийт өндөр нь ишний хамт 362,0 см, титэм /сэсэм/-ийн тойргийн голч нь 55,0 см, хөл, тугны нийт өндөр нь ишний хамт 262,0 см, титмийн тойргийн голч нь 40,0 см байна.

3.Төрийн тугны оройн хэсэгт гангаар сийлсэн, жийжүүдсэн хээтэй, сэрээ хэлбэрийн гилбэр байна. Их цагаан тугны гилбэрийн үзүүрт дээшээ дүрлэлэж байгаа галын дүрс байрлуулах бөгөөд гилбэр нь тойрсон цэцгийн дэлбээ хэлбэртэй суурь /цар/-тай байна. Уг суурь болон титмийн

туурга, гилбэрийн галын дүрсийг монгол дарханы аргаар алтдаж шармалдана.

4.Төрийн туг нь шаргал хээтэй цагаан хоргойгоор хийсэн 4 хэлт манжлага бүхий бүслүүртэй байна. Бүслүүр, хэлийн уулзвар бүр дээр зэс хөөмөл дугуй толь байрлуулна.

5.Их цагаан тугны гилбэрийн өндөр 58,5 см, галын дүрсний өргөн 36,0 см, гилбэр сэсмийг холбосон 4 ширхэг ган гархины өндөр 9,5 см, өргөн 7,5 см байна. Титмийн оройд тэнцүү хэмжээтэй 8 ширхэг цэцгийн дэлбээ байна. Их цагаан тугны титмийн туурганы өндөр 10,5 см, дээд, доод хажлаганы өргөн тус бүр 1,3 см, товрууны тойргийн голч нь 3,5 см, 4 хэлт манжлаганы урт 81,0 см, манжлаганы үзүүрийн улаан хүрэн өнгийн молцогны урт 18,0 см, манжлаганы хэл тус бүрийн дээд хэсгийн өргөн 7,5 см, үзүүр хэсгийн өргөн 10,5 см, бүслүүрийн өргөн 7,5 см, манжлага бүслүүрийн хүрэн улаан өнгөт эмжээрийн өргөн 1,0 см, хэл, бүслүүрийн уулзвар дахь зэс хөөмөл толины тойргийн голч нь 9,0 см хэмжээтэй байна.

6.Хөл тугны гилбэрийн өндөр 31,0 см, титмийн туурганы өндөр 9,0 см, дээд, доод хажлаганы өргөн тус бүр 1,0 см, товрууны тойргийн голч нь 2,5 см, 4 хэлт манжлаганы урт 61,0 см, манжлаганы хэл тус бүрийн дээд хэсгийн өргөн 6,5 см, үзүүр хэсгийн өргөн 9,5 см, бүслүүрийн өргөн 7,0 см, манжлага, бүслүүрийн хүрэн улаан өнгөт эмжээрийн өргөн 0,5 см, хэл, бүслүүрийн уулзвар дахь зэс хөөмөл толины тойргийн голч нь 7,0 см хэмжээтэй байна.

7.Төрийн тугны ишийг хус модыг хатааж, тосонд чанаж өнгөлж хийнэ. Их цагаан тугны ишний өндөр нь 303,5 см, голч нь 5,0 см, хөл тугны ишний өндөр нь 231,0 см, голч нь 3,5 см хэмжээтэй байна.

8.Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Төрийн тугийг дуурайлган үйлдэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Төрийн тугийг байрлуулах

1.Төрийн тугийг өнгийн чулуу шигтгэж, дотор нь Монгол Улсын бүх аймгийн хөрсний дээжийг байрлуулан цугтгасан, шаталсан хэлбэртэй хот, улсыг бэлэгдсэн хүрээ мандалын байдалтай суурь дээр залж Төрийн ордонд байрлуулна.

2.Төрийн тугийг газарт хүргэхийг цээрлэнэ.

10 дугаар зүйл. Төрийн тугийг хүндэтгэн залах

1.Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр баяр наадмын Төв талбайд Төрийн тугийг хүндэтгэн зална.



2.Төрийн тугийг хүндэтгэн залах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн далбаа, түүнийг үйлдэх, дүрслэх, мандуулах, байрлуулах

11 дүгээр зүйл.Төрийн далбаа

Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

12 дугаар зүйл.Төрийн далбааг үйлдэх

1.Төрийн далбааг улаан, хөх өнгийн хээгүй, цулгүй эдээр үйлдэнэ.

2.Төрийн далбааг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, өргөн уртын 1:2-ын харьцааг чанд баримтална.

13 дугаар зүйл.Төрийн далбааг мандуулах

1.Төрийн далбааг дараахь газар байнга мандуулна:

1/Монгол Улсын Төрийн ордон;

2/Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөө;

3/аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын албан ажлын байр;

4/Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын байр.

2.Төрийн далбааг дараахь газар, тээврийн хэрэгсэл дээр түр хугацаагаар мандуулна:

1/Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр-санал хураах байр;

2/Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын хуралдааны хугацаанд-хуралдааны байр;

3/Монгол Улсын Үндсэн хуулийн болон Монгол Улсыг Бүгд Найрамдах Улсаар

тунхагласан өдөр-төрийн захиргааны төв байгууллагын байр;

4/Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр-баяр наадмын талбай, төрийн захиргааны төв байгууллага,зэвсэгт хүчин, бусад цэргийн нэгтгэл, анги болон хилийн сумангийн байр;

5/Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон консулын хөлөглөж яваа тээврийн хэрэгсэл;

6/хилийн асуудлаар хэлэлцээ хийхээр яваа Монгол Улсын хилийн төлөөлөгчийн хөлөглөж яваа тээврийн хэрэгсэл.

3.Төрийн далбааг Монгол Улсын бүртгэлтэй усан тээврийн хэрэгсэл дээр олон улсын нийтлэг журмыг баримтлан мандуулна.

4.Олон улсын чанартай буюу үндэсний уламжлалт биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, наадам, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед олон улсын жишиг, ард түмний уламжлалыг харгалзан Төрийн далбааг өргөн мандуулж болно.

14 дүгээр зүйл.Төрийн далбааг байрлуулах, дүрслэх

1.Төрийн далбааг дараахь газар байнга байрлуулна:

1/Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүхийн шүүх хуралдааны танхим;

2/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга,Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн даргын албан тасалгаа;

3/бүх шатны Засаг даргын албан тасалгаа;

4/Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын албан тасалгаа;

5/хилийн төлөөлөгч, хилийн хороо, сумангийн даргын албан тасалгаа.

2.Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, усан тээврийн хэрэгсэл дээр олон улсын нийтлэг журмыг баримтлан Төрийн далбааг өнгөөр ялгаж дүрсэлнэ.

15 дугаар зүйл.Төрийн далбааг бөхийлгөх,



буулгах

Мандаж байгаа Төрийн далбааг орон даяар гашуудал зарласан тохиолдолд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулгана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн тамга, түүнийг үйлдэх, барих, залах, хадгалах

16 дугаар зүйл.Төрийн Тамга

Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар Төрийн тамга нь дөрвөлжин хэлбэртэй, голдоо Төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна.

17 дугаар зүйл.Төрийн тамгыг үйлдэх

1.Төрийн тамгыг цул мөнгөөр, гар аргаар, ганц хувь үйлдэнэ.

2.Төрийн тамга нь 10,0 x 10,0 x 2,0 см хэмжээтэй, арслангийн дүрс бүхий бариулын өндөр нь 8,0 см байна.

3.Төрийн тамганы дөрвөн өнцөгт бат бэхийг бэлгэдсэн холбоо түмэн насан хээ байрлуулан, Монгол Улс гэсэн бичээсийг монгол үсгээр эвхэж бичсэн байна.

4.Төрийн тамгыг дуурайлган үйлдэхийг хориглоно.

18 дугаар зүйл.Төрийн тамгыг барих, байрлуулах

1.Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина.

2.Төрийн тамгыг:

1/Монгол Улсын Үндсэн хуулийн үг эхийн хуудас бүр дээр;

2/Монгол Улсын хууль, Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээ, Монгол Улсаас гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн үг эхийн эхний хуудас дээр тус тус дарна.

3.Төрийн тамгыг үндэсний хээгээр чимэглэсэн мөнгөн тоног бүхий, зөвлөн торгомсог эдээр доторлосон зандан модон хайрцагт байрлуулна.

19 дүгээр зүйл.Төрийн тамгыг залах, хадгалах

Төрийн тамгыг залах журмыг Улсын Их Хурал, хадгалах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн дуулал, түүнийг эгшиглүүлэх, хүндэтгэх

20 дугаар зүйл.Төрийн дуулал

Монгол Улсын Төрийн дуулал нь энэ хуульд хавсаргасан үг, аятай байна.

21 дүгээр зүйл.Төрийн дууллыг эгшиглүүлэх

1.Төрийн дууллыг дараахь тохиолдолд эгшиглүүлнэ:

1/Төрийн тугийг хүндэтгэн залах ёслол үйлдэхэд;

2/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөсний дараа;

3/Монголын ард түмний баяр ёслолд зориулсан баярын хурал, цуглаан, ёслолын ажиллагааг нээхэд;

4/Монгол Улсын түүхэнд холбогдох болон эх орон, ард түмнийхээ өмнө гарамгай гавьяа байгуулсан хүмүүсийн дурсгалд зориулсан хөшөө, цогцолборыг нээхэд;

5/радио өргөн нэвтрүүлгийн үндсэн хөтөлбөр эхлэх, төгсөхөд;

6/бүх ард түмний баяр ёслолд зориулсан телевизийн хөтөлбөрийн анхны өдрийн нэвтрүүлэг эхлэхэд;

7/хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.

2.Олон улсын чанартай биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, наадам, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед олон улсын жишгийг баримтлан Төрийн дууллыг эгшиглүүлж болно.

3.Төрийн дууллыг найрал, үлээвэр хөгжим, дуу бичлэгийн хэрэгсэл ашиглан эгшиглүүлэх буюу найрал дуу, найрал дуу-хөгжим зэрэг бусад хэлбэрээр дуулж, хөгжимдөж болно.

4.Төрийн дууллыг энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 5-д заасан тохиолдолд бүрэн хэмжээгээр, бусад тохиолдолд эхний бадгийг дахилтын хамт эгшиглүүлнэ.

5.Цэргийн анги, нэгтгэлд Төрийн дууллыг

эгшиглүүлэх журмыг цэргийн дүрмээр зохицуулна.

22 дугаар зүйл. Төрийн дууллыг хүндэтгэх

Төрийн дууллыг олон нийтийн өмнө эгшиглүүлэхэд оролцогч бүх хүн босож хүндэтгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийг дүрслэх, үйлдэх зөвшөөрөл

1. Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар тогтооно.

2. Төрийн тугийг кино, уран сайхны бусад арга хэмжээнд зориулан дуурайлган үйлдэх зөвшөөрлийг Засгийн газар тухай бүр олгоно.

24 дүгээр зүйл. Төрийн ёслол, хүндэтгэлийн үед Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх

Монгол Улсын төр, засгийн тэргүүн нар гадаад оронд, гадаад орны төр, засгийн тэргүүн нар Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх, гадаад орноос Монгол Улсад суух элчин сайд итгэмжлэх жуух бичиг барих, түүнчлэн төрийн ёслол, хүндэтгэлийн бусад арга хэмжээний үед Төрийн сүлд, далбааг дээдлэн хэрэглэх, Төрийн дууллыг эгшиглүүлэх журмыг Монгол Улсын Төрийн ёслолын тухай хууль тогтоомжоор тодорхойлно.

25 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдэг хэрэглэх эрх чөлөө

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшигүүлж болно.

26 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийг гутаан доромжлохыг хориглох

Төрийн бэлгэ тэмдгийг гутаан доромжлохыг хориглоно.

27 дугаар зүйл. Хариуцлага

1. Энэ зүйлийн 5 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 8, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг санаатайгаар зөрчсөн бол иргэнд 5000 - 10000, аж ахуйн нэгж, байгууллагад 50000-75000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

1 Энэ хэсэгт 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлтийг тусгав!

2. Засгийн газраас тогтоосон журмыг зөрчиж Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрсэлсэн, Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр Төрийн тугийг кино, уран сайхны бусад арга хэмжээнд зориулан дуурайлган үйлдсэн, эсхүл Төрийн бэлгэ тэмдгийг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, устгах, гэмтээх зэргээр гутаан доромжилсон бол иргэнд 10000-25000, аж ахуйн нэгж, байгууллагад 50000-100000 төгрөгөөр торгох, эсхүл 14-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

1 Энэ хэсэгт 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлтийг тусгав!

3. Торгох шийтгэлийг шүүгч, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, баривчлах шийтгэлийг шүүгч ногдуулна.

28 дугаар зүйл. Хуулийн биелэлтэд тавих хяналт

Энэ хуулийн биелэлтэд тавих хяналтыг бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, гадаад харилцаа болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хилийн цэргийг удирдах газар хэрэгжүүлнэ.

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ДАРГА

Н. БАГАБАНДИ

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ

Монгол Улсын хуулийн хавсралт №1

Үгийг Ц. Дамдинсүрэн Аяаг Б. Дамдинсүрэн

Л. Мөрдорж

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДУУЛАЛ

Дархан манай хувьсгалт улс
 Даяар Монголын ариун голомт
 Дайсны хөлд хэзээ ч орохгүй
 Дандаа энхжиж үүрд мөнжинө

Хамаг дэлхийн шударга улстай
 Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж
 Хатан зориг, бүхий чадлаараа
 Хайрт Монгол орноо мандуульяа

Зоригт Монголын золтой ардууд
 Зовлонг тонилгож, жаргалыг эдлэв
 Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур
 Жавхлант манай орон мандтугай

Хамаг дэлхийн шударга улстай
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж
Хатан зориг, бүхий чадлаараа
Хайрт Монгол орноо мандуульяа

15.1. Олон улсын байгууллагын дэргэд суух
Монгол Улсын Байнгын төлөөлөгч, гадаад улсад суух
Монгол Улсын Ерөнхий консулыг Монгол Улсын
Ерөнхий сайд томилж, эгүүлэн татна.

II ХЭСЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДИПЛОМАТ ЁСЛОЛ

11. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримталдаг ёс горим, зан заншил, тогтсон хэм хэмжээг бүхэлд нь төрийн дипломат ёслол гэнэ.

Монгол Улсын төрийн дипломат ёслол нь үндэснийхээ онцлог, зан заншлыг илэрхийлэхийн хамт олон улсын хэмжээнд тогтсон уламжлал, заншил, нийтлэг зарчим, хэм хэмжээнд нийцэж байвал зохино. Тухайлбал Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенцийн заалтуудад тулгуурлана.

12. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх

12.1. Монгол Улс гадаад улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөө албан ёсоор мэдэгдэнэ.

13. Дипломат харилцаа тогтоох

13.1. Монгол Улсаас бусад улстай дипломат харилцаа тогтоох тухай баримт бичгийг олон улсын харилцаа, эрх зүйн практикт нийцүүлэн харилцан тохиролцсон хэлбэрээр гүйцэтгэнэ.

14. Элчин сайд томилох, хавсруулан томилох, эгүүлэн татах

14.1. Элчин сайдыг тохоон томилохын өмнө ГХЯ хүлээн авагч улсын Засгийн газраас тухайн хүнд агреманьг (зөвшөөрөл) дипломат шугамаар хүсч авна. Агреманьг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасны дагуу элчин сайдыг тохоон томилж, эгүүлэн татна.

14.2. Монгол Улс элчин сайдыг нэг буюу хэд хэдэн улсад хавсруулан томилж болно. Элчин сайдыг хавсруулан томилохдоо суугаа болон хавсран суух гэж байгаа орны Засгийн газрын байр суурийг урьдчилан мэдэж харгалзан үзнэ.

14.3. Шинээр томилогдсон элчин сайд суурин сууж ажиллах улсад явахын өмнө Монгол улсын Ерөнхийлөгчид бараалхаж итгэмжлэх жуух бичгээ гардан хүлээн авна. Ерөнхийлөгч Элчин сайдад захиа даалгавар өгнө.

15. Байнгын төлөөлөгч, Ерөнхий консулыг томилох, эгүүлэн татах

16. Дипломат төлөөлөгчийн газар

16.1. Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий Консулын газар, Консулын газар болон Консулын төлөөлөгчийн газар тус тус хамаарна.

16.2. Дипломат төлөөлөгчийн газрыг холбогдох хууль тогтоомжийн дугуу томилогдсон тэргүүн удирдана.

16.3. ДТГ-ын тэргүүн суугаа улс, олон улсын байгууллагадаа түр хугацаагаар эзгүй байх тохиолдолд түүний дараахь ахлах зиндааны дипломат ажилтныг хэргийг түр хамаарагчаар үлдээж, энэ тухай суугаа улс, олон улсын байгууллагад болон дипломат корпус албан ёсоор мэдэгдэнэ.

16.4. ДТГ дипломат ёслолын үйл ажиллагаандаа энэхүү журмыг удирдлага болгон суугаа улс, олон улсын байгууллагын ёслолын журам, олон улсын практик, хэм хэмжээг баримтална.

17. ДТГ-ыг нээх, шинэ байранд шилжин орох

17.1. ДТГ-ыг нээх, шинэ байранд шилжин ороход суугаа улсын Гадаад хэргийн яам, ажил хэргийн холбоотой бусад яам, байгууллага, олон улсын холбогдох байгууллагын удирдлага, дипломат корпус, хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг урьж, ДТГ-ын байрны хаягийг нээж төрийн далбаа мандуулан, төрийн дуулал эгшиглүүлэн ёслож болно.

18. Итгэмжлэх болон эгүүлэн дуудах жуух бичиг үйлдэх

18.1. Шинээр томилогдсон элчин сайдад Итгэмжлэх жуух бичиг, өмнөх элчин сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн тухай эгүүлэн дуудах жуух бичиг шийтгэн олгоно.

18.2. Жуух бичгийг 33 x 22 см хэмжээний хамар буюу нугалбар цагаан цаасан дээр үйлдэнэ. Нүүрэн талд нь төрийн сүлдийг товойлгосон байх бөгөөд түүний доод хэсэгт голлуулан крилл үсгээр "Монгол Улсын Ерөнхийлөгч..." гэж овог, нэрийг хэвлэсэн байна. Жуух бичгийн орчуулгыг англи хэлээр үйлдэж хавсаргана.



18.3. Жуух бичгийн эх хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч гарын үсэг зурна. Гадаад харилцааны сайд үүнийг баталгаажуулан гарын үсэг зурна.

18.4. Жуух бичиг дугтуйтай байна. Дугтуйн гадна талд "...Улсын Ерөнхийлөгч (Эзэн хаан/ Хатан хаан) Эрхэмсэг ноён /хатагтай/... Танаа" гэж овог, нэрийг крилл үсгээр бичнэ. Дугтуйг битүүмжлэхгүй. Харин дугтуйн амсрын гурвалжин дээр Монгол улсын сүлдийг товойлгож хэвлэсэн тусгай даруулга наасан байна.

19. Итгэмжлэх болон эгүүлэн дуудах захидал үйлдэх

19.1. Шинээр томилогдсон Байнгын төлөөлөгчид итгэмжлэх захидал, өмнөх Байнгын төлөөлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн тухай эгүүлэн дуудах захидал шийтгэн олгоно.

19.2. Итгэмжлэх захидлыг 33 x 22 см хэмжээний хамар буюу нугалбар цагаан цаасан дээр үйлдэнэ. Нүүрэн талд нь төрийн сүлдийг товойлгосон байд бөгөөд түүний доод хэсэгт голлуулан крилл үсгээр "Монгол Улсын Ерөнхий сайд..." гэж овог, нэрийг хэвлэсэн байна. Итгэмжлэх захидлын орчуулгыг англи хэлээр үйлдэж хавсаргана.

Итгэмжлэх захидлын эх хувьд Монгол Улсын Ерөнхий сайд гарын үсэг зурна. Гадаад харилцааны сайд үүнийг баталгаажуулан гарын үсэг зурна.

Итгэмжлэх захидал дугтуйтай байна. Дугтуйн гадна талд тухайн олон улсын байгууллагын тэргүүний овог, нэрийг крилл үсгээр бичнэ. Дугтуйг битүүмжлэхгүй. Харин дугтуйн амсрын гурвалжин дээр Монгол улсын сүлдийг товойлгож хэвлэсэн тусгай даруулга наасан байна.

20. Итгэмжлэх жуух бичиг, итгэмжлэх захидал гардуулах

20.1. ДТГ-ын тэргүүн энэ журмын 18, 19-д заасан Итгэмжлэх жуух бичиг, Итгэмжлэх захидлыг тухайн улс, олон улсын байгууллагад дагаж мөрддөг ёслолын журам, олон улсын практик, хэм хэмжээг баримтлан гардуулна.

21. Дипломат харилцаа цуцлах, ДТГ-ыг хаах

21.1. Монгол Улс гадаад улстай тогтоосон дипломат харилцааг цуцлавал албан ёсны шийдвэрээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэнэ.

21.2. Монгол Улс ДТГ-аа хаахдаа учир шалтгааныг тайлбарлан хэргийг хаанаас хавсруулан хамааруулахаа нөгөө талд ноотоор мэдэгдэнэ.

22. Гадаадын ДТГ-ын тэргүүнийг хүлээн авах

22.1. Гадаадын ДТГ-ын шинээр томилогдсон тэргүүн анх удаа хүрэлцэн ирэхэд нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд Ёслолын хэлтсийн дарга (түүний эзгүйд түүнийг орлох ажилтан энэ үүргийг гүйцэтгэх бөгөөд цаашид "Ёслолын хэлтсийн дарга" гэнэ) угтана.

22.2. ДТГ-ын тэргүүнийг үүрэгт ажилдаа эхлэн орох гэж байгаатай нь холбогдуулан Ёслолын хэлтсийн дарга, Гадаад харилцааны сайд (сайдын эзгүйд ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга энэ үүргийг гүйцэтгэх бөгөөд цаашид "Гадаад харилцааны сайд" гэнэ) тус тус хүлээн авч уулзана. Ёслолын хэлтсийн дарга ДТГ-ын тэргүүнийг хүлээн авахдаа Итгэмжлэх жуух бичиг буюу Итгэмжлэх захидал гардуулах ёслолын журмыг тайлбарлаж өгнө. Гадаад харилцааны сайд элчин сайдтай уулзахдаа түүний Итгэмжлэх жуух бичиг болон өмнөх элчин сайдыг үүрэгт ажлаас чөлөөлсөн тухай эгүүлэн дуудах жуух бичгийн хувийг хүлээн авна.

22.3. ГХЯ элчин сайдын товч намтар, хоёр улсын харилцааны болон тухайн улсын талаархи лавлахуудыг бэлтгэж Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслол болохоос өмнө Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн байна.

22.4. Ёслолын хэлтэс ДТГ-ын тэргүүний Итгэмжлэх жуух бичгийг тэргүүний ирснээс хойш 14 хоногт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгчид бариулна.

22.5. Ёслолын хэлтэс элчин сайдын Итгэмжлэх жуух бичиг гардуулах өдөр, цагийг Ерөнхийлөгчийн Тамгын газартай урьдчилан тохирч Ёслолын хэлтсийн дарга товыг хувийн ноотоор элчин сайдад мэдэгдэнэ.

23. Итгэмжлэх жуух бичиг гардуулах

23.1. Итгэмжлэх жуух бичгийг Төрийн ордны "Соёмбо" танхим буюу Төрийн хүндэтгэлийн өргөөнд хүлээн авна. Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслолын үед төрийн ордны гол хаалганы баруун талын багананд тухайн улсын, зүүн талын багананд Монгол улсын төрийн далбаа мандуулах бөгөөд далбааны хэмжээ 3 x 1,5 м байна.

Төрийн ордны өмнөх талбайд Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн бунхны баруун жигүүрт төрийн ёслолын хүндэт харуул зүүн тийш харж жагсана. Хүндэт харуулын туг жагсаалын эхэнд байрлана. Бунхны ард Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим Төрийн ордон руу харж жагсана.

23.2. Ёслолын хэлтсийн дарга элчин сайдыг Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслол эхлэх цагаас

5 минутын өмнө тусгай зориулалтын машинаар Төрийн ордонд авчирна. Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслолд элчин сайдын гэргий, дипломатууд дагалдан оролцвол өөрсдийн автомашинаар тусгай зориулалтын машиныг дагалдан Төрийн ордонд ирнэ.

23.3. Тусгай зориулалтын машин Төрийн ордны зүүн талын нуман хаалгаар орж ирэхэд үлээвэр хөгжимд угтах марш эгшиглүүлэх бөгөөд төрийн ордны өмнөх талбайд ирж зогсоход хамгаалалтын офицер машины хаалгыг онгойгож элчин сайдыг хүндэтгэн ёсолно. Энэ үед бусад машин элчин сайдын машины ард нэгэн эгнээнд цуван зогсоно.

23.4. Ёслолын хэлтсийн дарга элчин сайдыг баруун гар талдаа дагуулан хүндэт харуулын зүг алхаж тусгайлан дэвсгэн хивсэн дээр очиж зогсоно. Энэ үед элчин сайдын гэргий, дагалдах дипломатууд элчин сайдын машины өмнүүр нэг эгнээгээр баруун гар талаас ёслолын ахлалыг баримтлан зогсоно. Хүндэт харуулын захирал цэргүүддээ "Номхон" команд өгөөд элчин сайдыг угтан ирж 5 метр орчим зайд түүний өөдөөс эгцлэн харж зогсоод "...улсаас Монгол улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён (хатагтай) Таныг хүндэтгэн Төрийн хүндэт харуул жагссан. Хүндэт харуулын захирал" гээд цэргийн цол, нэрээ хэлж айлтгал өргөнө. Айлтгал өргөсний дараа хүндэт харуулын захирал баруун гар тийш эргэн элчин сайд өөд хараа шилжүүлэн зогсоход үлээвэр хөгжим хоёр улсын төрийн дуулал эгшиглүүлнэ. Үүний дараа Ёслолын хэлтсийн дарга элчин сайдын хамт үлээвэр хөгжийн өмнүүр алхан өнгөрч хүндэт харуулын тугийн өмнө очоод толгой мэхийн ёсолно. Эндээс Ёслолын хэлтсийн дарга элчин сайдыг зүүн гар талдаа авч харуулын жагсаалын урдуур явж дунд хэрд нь хүрээд зогсоход элчин сайд "Цэргүүд сайн байна уу?" гэж мэндэлнэ. Хүндэт харуул "Амрыг эрье" хэмээн хариу мэндэлнэ.

Ёслолын хэлтсийн дарга элчин сайдын хамт хүндэт харуулын жагсаалын төгсгөлд хүрч элчин сайдыг баруун гар талдаа авч Төрийн ордны гол хаалга руу явна. Элчин сайдыг дагалдан яваа түүний гэргий, дипломатууд гол хаалганд тосон ирж элчин сайд, Ёслолын хэлтсийн даргын араас цувран Төрийн ордонд орно. Энэ үед хамгаалалтын хоёр офицер ордны гол хаалганы гадна ёсолж хүндэтгэн өнгөрүүлнэ.

23.5. Итгэмжлэх жуух бичиг хүлээн авах ёслолыг одоо мөрдөж байгаа журмын дагуу зохион байгуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч Итгэмжлэх жуух бичгийг хүлээн аваад элчин сайдтай уулзаж ярилцана. Энэ уулзалт 20-25 минут болно. Гадаад харилцааны сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга орно. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

23.6. Итгэмжлэх жуух бичиг гардуулсан

элчин сайдад албан үүргээ гүйцэтгэж эхэлсэнтэй нь холбогдуулж Гадаад харилцааны сайд зоог барьж болно. Чингэхдээ хоёр орны харилцааны түвшин, харилцан адил байх зарчмыг харгалзаж байвал зохино.

24. Хэргийг хамаарагч, суурин төлөөлөгчийг угтах

24.1. Монгол Улсад суух гадаад улсын хэргийг хамаарагч, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч анх удаа хүрэлцэн ирэхэд Ёслолын хэлтсийн дарга нисэх онгоц /галт тэрэг /-ны буудалд угтана.

25. Итгэмжлэх захидал гардуулах

25.1. Хэргийг хамаарагч, суурин төлөөлөгчийн Итгэмжлэх захидлыг түүний ирснээс хойш 14 хоногт багтаан Гадаад харилцааны сайдад /түүний эзгүй байх тохиолдолд ГХЯ-ны ТНБД-д/ бариулна. Ёслолын хэлтсийн дарга хэргийг хамаарагч, суурин төлөөлөгчид Итгэмжлэх захидал гардуулах өдөр, цагийг хувийн ноотоор мэдэгдэнэ.

25.2. Хэргийг хамаарагч, суурин төлөөлөгч Итгэмжлэх захидал гардуулах үеэр ГХЯ-ны гол хаалганы баруун талд тухайн улсын буюу олон улсын байгууллагын далбааг, зүүн талд Монгол Улсын төрийн далбааг тус тус мандуулна.

26. ДТГ-ын тэргүүнтэй уулзах

26.1. ДТГ-ын тэргүүн Итгэмжлэх жуух бичиг буюу Итгэмжлэх захидал гардуулж үүрэгт ажилдаа орсон, албан томилолтоо дуусгаж эх орондоо бүрмөсөн буцах болсон хийгээд ажил хэргийн бусад асуудлаар өөрийн хүсэлтээр төр, засгийн удирдагчид, тэдний орлогчтой танилцах, салах ёс гүйцэтгэх болон ажлын уулзалт хийж болно. ДТГ-ын тэргүүн ийм хүсэлтээ Ёслолын хэлтэст урьдчилан мэдэгдэнэ. Ёслолын хэлтэс уулзалтыг хоёр орны харилцааны түвшин, харилцан адил байх зарчмыг харгалзан зохицуулна.

26.2. Монгол улсад суурин суугаа ДТГ-ын тэргүүн эх орондоо бүрмөсөн буцахад Гадаад харилцааны сайд үдэлтийн зоог барьж дурсгалын зүйл өгч болно.

Хоёр орны харилцааны түвшинг харгалзан ДТГ-ын тэргүүнийг онцгойлон үзэх тохиолдолд төр, засгийн удирдагчдын нэг нь түүнд хувийн зоог барьж болно.

26.3. Монгол улсад суугаа ДТГ-ын тэргүүн эх орондоо бүрмөсөн буцахад Ёслолын хэлтсийн дарга нисэх онгоц буюу галт тэрэгний буудлаас үдэж мордуулна.

27. Дипломат корпус

Еслолын хэлтсээр дамжуулан тавина;

б) төр, засгийн удирдагчид болон УИХ-ын дэд дарга ДТГ-ын тэргүүн, гадаад улсын төр, олон нийтийн зүтгэлтэн, хэвлэл мэдээлэл, ажил хэргийн хүмүүс, өргөмжит консулыг хүлээн авч уулзахад ГХЯ-ны холбогдох газар, хэлтсээс хүн байлцана. Орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

28.8. Гадаад харилцааны сайд дипкорпустай харилцах. Үүнд:

а) тус улсад суух ДТГ-ын тэргүүнийг энэхүү журмын 23, 26.1-д заасан асуудлаар болон өөрийн санаачилгаар хүлээн авч уулзана;

б) аргын тооллын шинэ жилээр ДТГ-ын тэргүүн нарт бэлэг илгээж мэндчилгээний хуудсаар баяр хүргэнэ.

29. Гадаадын ДТГ-ын гишүүдийг бүртгэх, үнэмлэх олгох

29.1. ДТГ-ын тэргүүн, гишүүд, тэдгээрийн гэр бүлийг Еслолын хэлтэс бүртгэж, паспортад нь бичигдсэн албан тушаал, ДТГ-ын албан ёсны бичиг баримтыг үндэслэн дараахь төрлийн хувийн үнэмлэх олгоно. Үүнд:

а) дипломат үнэмлэх-Д;

б) ажилтны үнэмлэх-А;

в) олон улсын байгууллагад ажиллагсдын үнэмлэх-ОУ;

г) олон улсын байгууллагын шугамаар яам, бусад албан байгууллагад ажиллагсдын үнэмлэх-ОУТ.

Үнэмлэх дээр Еслолын хэлтсийн дарга гарын үсэг зурж тамга дарна.

Шаардлагатай гэж үзвэл дээр дурдсан ДТГ-ын тэргүүн буюу гишүүний хүүхдийн паспорт дээр Еслолын хэлтсийн тамга дарж, эцэг буюу эхийн хувийн үнэмлэхийн төрөл, дугаар, олгосон он, сар, өдрийг тэмдэглэж болно.

29.2. ДТГ-ын тэргүүн болон аль нэг гишүүн албан томилолтынхоо хугацааг дуусган эх орондоо буцахдаа Еслолын хэлтэст албан ёсоор мэдэгдэж, хувийн үнэмлэхээ эгүүлэн хураалгаж, бүртгэлээс хасуулна.

30. Гадаадын ДТГ-ыг нээх, шинэ байранд шилжин орох

30.1. Гадаад улс, Засгийн газар хоорондын олон улсын байгууллага Монгол улсад ДТГ нээх, шинэ байранд шилжин оруулах хүсэлтээ хоёр талын тохиролцоог үндэслэн Еслолын хэлтэст дипломат шугамаар тавина.

31. Гадаадын ДТГ-ыг хаах

31.1. Гадаад улс, олон улсын байгууллага ДТГ-аа хаах асуудлаар тухайн ДТГ-ын тэргүүн Еслолын хэлтэст албан ёсоор мэдэгдэж ноот өгнө.

32. Дипломат ёслолын баримт бичиг

32.1. Төр, засгийн удирдагчид болон Гадаад харилцааны сайдаас гадаад улсын төр, засгийн удирдагчид, олон улсын байгууллагын болон ДТГ-ын тэргүүн нарт илгээх (хүлээн авах) баримт бичгийг дээд болон өндөр хэмжээнд солилцох дипломат ёслолын баримт бичиг гэнэ. Дээд болон өндөр хэмжээнд солилцох дипломат ёслолын баримт бичигт цахилгаан утас, илгээлт, итгэмжлэх жуух бичиг болон итгэмжлэх захидал, ноот, урилга, санамж бичгийг хамааруулна.

Дээд болон өндөр хэмжээнд солилцох дипломат ёслолын баримт бичиг нь төлөөлсөн болон биечилсэн хэлбэртэй, төр, засгийн удирдагчид болон дээд, өндөр албан тушаалтны албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр хийгдэнэ. Дээд болон өндөр хэмжээнд солилцох дипломат ёслолын баримт бичгийн хэлбэр, бичвэрийг ГХЯ холбогдох албан тушаалтантай зөвшилцсөний үндсэн дээр эцэслэн боловсруулж илгээнэ.

32.2. Гадаадад албан ёсны болон ажлын айлчлал хийж буй төр, засгийн удирдагчид бусад улсын нутгаар дамжин өнгөрөхдөө тухайн улсын төр, засгийн адилтгах албан тушаалтанд мэндчилгээ дэвшүүлж нисэх онгоц буюу галт тэрэгнээс цахилгаан утас илгээж болно.

32.3. Гадаадад албан ёсны болон ажлын айлчлал хийсэн төр, засгийн удирдагч тухайн улсын төр, засгийн адилтгах албан тушаалтанд захидал илгээж талархал илэрхийлж болно.

32.4. Дипломат харилцаатай улсын үндэсний баяраар Ерөнхийлөгч, Гадаад харилцааны сайд тухайн улсын холбогдох хүмүүст баяр хүргэж цахилгаан утас илгээнэ.

32.5. Гадаад орны төр, засгийн удирдагчид, Гадаад хэргийн сайд шинэ албан тушаалд ороход болон тэдний насны тэгш ой, бусад томоохон үйл явдал, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын тэгш ойг тохиолдуулан Монгол улсын холбогдох албан тушаалтан, байгууллага цахилгаан утас илгээнэ. Чингэхдээ харилцааны түвшин, харилцан адил байх зарчим, тухайн үеийн онцлогийг тусгасан бэлэг, дурсгалын зүйлийг дагалдуулж болно.

33. Төр, засгийн удирдагчдын айлчлал

33.1. Төр, засгийн удирдагчдын гадаадад хийх айлчлалыг төрийн, албан ёсны, ажлын, хувийн гэж ангилна. Айлчлалын албан ёсны нэр,



хөтөлбөрийг ГХЯ нөгөө талтай урьдчилан тохиролцоно. Төрийн айлчлалыг зөвхөн Ерөнхийлөгч хийнэ.

Төр, засгийн удирдагч тухайн улсад анх удаа айлчлах, харилцаа, хамтын ажиллагааны онцгой чухал асуудал хэлэлцэх, баримт бичигт гарын үсэг зурах зэрэг зорилгоор айлчилбал төрийн буюу албан ёсны айлчлалд хамруулна.

Хоёр талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ явуулах, зөвлөлдөх, олон улсын хурал, чуулган, спортын баяр, бусад арга хэмжээнд оролцох зорилгоор явж буй бол ажлын айлчлалд хамруулна.

33.2. Төр, засгийн удирдагчид гадаадад айлчлахдаа "МИАТ" компанийн тусгай онгоц хөлөглөж болно.

33.3. Төр, засгийн удирдагчид албан ёсны айлчлалаар гадаадад явахад нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд төрийн далбаа мандуулж, нисэх онгоц буюу галт тэрэгний шатанд гудаслаг улаан хивс дэвсэнэ.

33.4. Төр, засгийн удирдагчдын хөлөглөх нисэх онгоц буюу галт тэрэгний дарга түүнд нисэх онгоц буюу галт тэрэг бэлэн болсныг илтгэж айлтгал өргөнө.

34. Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал

34.1. Ерөнхийлөгч гадаадад төрийн буюу албан ёсны айлчлалаар явахад түүний гэргий, албан ёсны болон ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний 21 хүртэл хүн дагалдаж явж болно. Үүнд:

а) Гадаад харилцааны сайдыг оролцуулан УИХ, Засгийн газрын холбогдох гишүүн 3 хүртэл хүн;

б) тухайн оронд суугаа элчин сайд гэргийн хамт;

в) Ерөнхийлөгчийн Тамгын газраас 3 хүртэл хүн;

г) ГХЯ-наас 3 хүртэл хүн;

д) холбогдох яам, тусгай газрын зөвлөх мэргэжилтэн 2 хүртэл хүн;

е) эмч, үйлчилгээний хэсэг 2 хүртэл хүн;

ж) хамгаалалтын хэсэг 3 хүртэл хүн;

з) баримтат кино, гэрэл зурагчин 2 хүртэл хүн;

и) хэлмэрч 1 хүн.

Айлчлах улсын тоо, тухайн цаг үеийн нөхцөл зэргээс хамаарч дагалдах бүрэлдэхүүний тоо дээр дурдсанаас өөр байж болно.

34.2. Ерөнхийлөгч гадаадад ажлын айлчлалаар явахад гэргий дагалдахгүй, харин албан ёсны болон ажлын, хамгаалалт-үйлчилгээний хэсэг бүгд 18 хүртэл хүн дагалдан явж болно.

34.3. Ерөнхийлөгч төрийн, албан ёсны болон ажлын айлчлалаар гадаадад явах, гадаадаас ирэхэд УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Батлан хамгаалахын сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /дарга дагалдах тохиолдолд орлогч нь/, Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн зөвлөхүүд үдэж, угтана. Холбогдох улс, олон улсын байгууллагаас тус улсад суугаа ДТГ-ын тэргүүнийг үдэх, угтах арга хэмжээнд урина.

35. УИХ-ын даргын айлчлал

35.1. УИХ-ын дарга гадаадад албан ёсны айлчлалаар явахад гэргий, албан ёсны болон ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний бүгд 12 хүртэл хүн дагалдан явж болно. Үүнд:

а) УИХ-ын гишүүн 3 хүртэл хүн;

б) УИХ-ын Тамгын газраас 2 хүртэл хүн;

в) эмч, үйлчилгээний хэсэг 2 хүртэл хүн;

г) хамгаалалтын хэсэг 3 хүртэл хүн;
д) хэлмэрч 1 хүн.

Айлчлах улсын тоо, тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч бүрэлдэхүүний тоо дээр дурдсанаас өөр байж болно.

35.2. УИХ-ын дарга гадаадад ажлын айлчлалаар явахад гэргий дагалдахгүй, харин албан ёсны болон ажлын, хамгаалалт-үйлчилгээний хэсэг бүгд 6 хүртэл хүн дагалдаж болно.

35.3. УИХ-ын даргыг албан ёсны болон ажлын айлчлалаар явахад УИХ-ын дэд дарга, Гадаад харилцааны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга үдэж, угтана. Холбогдох улс, олон улсын байгууллагаас тус улсад суугаа ДТГ-ын тэргүүнийг үдэж, угтах арга хэмжээнд урина.

36. Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлал

36.1. Ерөнхий сайд гадаадад албан ёсны айлчлалаар явахад гэргий, албан ёсны болон ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний албаны бүгд 16



ёсны айлчлалд хамруулна.

Гадаад улсын төр, засгийн удирдагчид хоёр орны харилцаа, бус нутгийн хийгээд олон улсын байдлын асуудлаар зөвлөлдөх, санал солилцох, олон талын баримт бичигт гарын үсэг зурах, хурал зөвлөлдөөн, урлаг, соёл, спортын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдалд оролцох, эмгэнэл илэрхийлэх буюу дамжин өнгөрөх зорилгоор тус улсад хийж буй айлчлалыг ажлын айлчлал гэж үзнэ.

Гадаад улсын төр, засгийн удирдагчид эмчлүүлэх, сувилуулах, ан хийх, аялан жуулчлах зорилгоор тус улсад хийж буй айлчлалыг хувийн айлчлал гэж үзнэ.

40.2. Гадаад улсын төр, засгийн удирдагчдын Монголд хийх айлчлалын нэр, хөтөлбөрийг нөгөө талтай хэлэлцэж тохиролцоно.

41. Гадаадын төрийн тэргүүний төрийн болон албан ёсны айлчлал

41.1. Нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд угтах. Үүнд:

а) угтах ёслолын ажиллагаа нисэх онгоц буюу галт тэрэгний буудлаас эхлэх бөгөөд буудалд байрлуулсан тугны ишний зүүн гар талынхад Монгол улсын, баруун гар талынхад тухайн улсын төрийн буюу тухайн төрийн тэргүүний далбааг мандуулж, нисэх онгоц буюу галт тэрэгний шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна. Төрийн тэргүүний зорчих замын хоёр хажуугийн шонд Чингисийн өргөн чөлөөнд Энх тайвны хаалганаас Төв шуудан хүртэл, Энх тайвны өргөн чөлөөнд УБИС-иас МЭТНБ-ын холбоог хүртэл, Олимпын өргөн чөлөөнд ГХЯ-наас төмөр замын гарц хүртэл Монгол Улсын төрийн далбаа, тухайн улс эсвэл тухайн төрийн тэргүүний далбааг мандуулна;

Сүхбаатарын талбайн өмнөх цэцэрлэгт "Монгол Улсад төрийн /албан ёсны/ айлчлал хийж байгаа ... улсын...Эрхэмсэг ноён /хатагтай/...Танд чин сэтгэлийн баяр хүргэе" гэсэн өрөөл бүхий самбарыг монгол, тухайн улсын буюу тохиролцсон аль нэг хэлээр бичиж байрлуулна.

б) төрийн тэргүүнийг Монгол улсын Гадаад харилцааны сайд (гэргий/нөхөр) тухайн улсад суугаа Монгол улсын элчин сайд, Ёслолын хэлтсийн дарга угтана.

41.2. Сүхбаатарын талбайд угтах

41.2.1. Сүхбаатарын талбайн төв хэсэг дэх тугны ишний баруун талынхад тухайн улсын төрийн буюу төрийн тэргүүний, зүүн талынхад Монгол улсын төрийн далбаа, тэдгээрийн дунд Улаанбаатар хотын далбааг мандуулна. Төрийн далбаануудын баруун

талд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим, төрийн ёслолын хүндэт харуул /72 цэрэг/ зүүн тийш харж жагсана. Хүндэт харуулын эхэнд хүндэт харуулын тугийг байрлуулна.

Гадаад улсын төрийн тэргүүнийг угтах Монголын талын албаны хүмүүс хүндэт харуулын зүүн гар талд урагш харан баруун гар талаас ёслолын ахлалын дарааллаар зогсоно.

Мандуулсан далбаануудын зүүн талд хоёр улсын төрийн тэргүүнд зориулж 3x2 м хэмжээтэй тавцан тусгайлан зассан байна. Уг тавцан зүүн, баруун талдаа нээлттэй байх бөгөөд бусад шонгуудыг хооронд нь улаан туузаар холбосон байна. Шонгууд өндөр нь 70 см байна.

Монгол улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнтэй анх уулзаж гар барих газар хивс дэвссэн байна. Тэр цэгээс эхлэн ёслол үйлдэх бүх замын дагуу улаан өнгөтэй гудаслаг хивс үргэлжлүүлэн дэвсэнэ.

Төрийн тэргүүний хөлөглөсөн машин Сүхбаатарын талбай руу гарч ирэхэд үлээвэр хөгжимд угтах марш эгшиглэнэ. Зочны машин заасан газарт ирж зогсоход төрийн ордны хамгаалалтын албаны хоёр офицер төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-н талын хаалгыг нээн өгч ёсолно. Төрийн тэргүүн түүний гэргий /нөхөр/, Гадаад харилцааны сайдын хамт угтахгаар ирсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүг явахад Монгол Улсын Ерөнхийлөгч /гэргийн хамт/ мөн тэдний зүг алхаж хивсний голд уулзан гар барьж мэндэлнэ. Энэ үед гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-д үндэсний хувцастай эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд амьд цэцгийн баглаа барина. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч, тусгайлан зассан тавцанд гарахад хүндэт харуулын захирал угтан ирж "Монгол Улсад төрийн /албан ёсны/ айлчлал хийж байгаа ...улсын Ерөнхийлөгч (Эзэн хаан/Хатан хаан) Эрхэмсэг ноён /хатагтай/.... Таныг хүндэтгэн Монгол Улсын төрийн хүндэт харуул жагссан. Хүндэт харуулын захирал..." гэж цэргийн цол, овог, нэрээ хэлж айлтал өргөнө. Хүндэт харуулын захирал байрандаа баруун гар тийш эргэж Монгол Улсын Ерөнхийлөгч болон гадаад улсын төрийн тэргүүн өөд хараа шилжүүлэн зогсоход хөгжим эхлээд тухайн улсын буюу төрийн тэргүүнд хамаарах дуулал, дараа нь Монгол Улсын төрийн дуулал тоглоно. Энэ үед Ерөнхийлөгчийн гэргий гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гартаа авч, тавцангийн зүүн талд хоёр метр орчим зайд зогсоно. Гадаад харилцааны сайд хоёр төрийн тэргүүний гэргий нарын ард зогсоно.

Төрийн дуулал эгшиглэж дуусахад Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүний хамт тавцангаас бууж хүндэт харуулын зүг явна. Хүндэт харуулын захирал гурван алхмын зайд

дагалдан явна. Хоёр орны төрийн тэргүүн нар хүндэт харуулын жагсаалын эхэнд залсан хүндэт харуулын туганд толгой мэхийн хүндэтгэл илэрхийлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг эндээс эхлэн зүүн гартаа авч, цааш явж жагсаалын дунд хэрд очоод цэргүүд рүү харж түр зогсоно. Гадаад улсын төрийн тэргүүн "сайн байцаана уу" гэж мэндэлнэ. Хүндэт харуулын цэргүүд "амрыг эрбэ" гэж хариу мэндэлнэ.

Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар хүндэт харуулын өмнүүр явж өнгөрөөд монголын талын албаны хүмүүсийн зүг эргэн явна. Хүндэт харуулын захирал дорoo эргэж хүндэт харуул тиийш алхана. Энэ үед Ерөнхийлөгчийн гэргий, гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/, төрийн тэргүүнийг угтсан Гадаад харилцааны сайд тэдний араас дагалдан явж, утгагсадтай мэндчилнэ. Ёслолын хэлтсийн дарга монголын талын албаны хүмүүсийг танилцуулна.

Монголын талын албаны хүмүүсийн дор гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа төлөөлөгчид баруун гар талаас ёслолын ахлалаар эгнэн зогсоно. Нөгөө талын ёслолын хэлтсийн дарга /ажилтан/ өөрийн талын төлөөлөгчдийг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна.

Гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа төлөөлөгчдийн дор тухайн улсаас тус улсад суугаа ДТГ-ын гишүүд зогсоно. Тэднийг тухайн ДТГ-ын тэргүүн танилцуулна. Үүгээр угтах ёслол өндөрлөнө.

41.3. Төрийн тэргүүний байрлах байр

Монгол Улсад төрийн буюу албан ёсны, ажлын айлчлал хийх гадаад улсын төрийн тэргүүнийг хаана байрлуулахыг нөгөө талтай урьдчилан тохирно.

Гадаад улсын төрийн тэргүүний байрлах Харш буюу зочид буудлын өмнө талд тухайн улсын төрийн буюу төрийн тэргүүний далбааг мандуулна.

Гадаад улсын төрийн тэргүүнийг нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд угтсан албан тушаалтан /Гадаад харилцааны сайд/ Харш буюу зочид буудалд хүргэж ирнэ. Харш буюу зочид буудлын дарга хүндэт зочныг анх очиход угтаж, явахад нь үдэж явуулна.

41.4. Төрийн тэргүүний хөлөглөх машин

Монгол Улсад төрийн буюу албан ёсны, ажлын айлчлал хийх гадаад улсын төрийн тэргүүнд тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Тусгай зориулалтын машины бэлэн байдал, найдвартай ажиллагааг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Төрийн тусгай хамгаалалтын газар шалгаж урьдчилан бэлтгэсэн байна. Магнайн машин гаргаж үйлчилнэ.

Гадаад улсын төрийн тэргүүний хөлөглөх машин, ёслол, хамгаалалтын машинд гадагшаа харилцах холбооны аппарат хэрэгсэл суурилуулсан байна.

41.5. Төрийн тэргүүний хувийн хамгаалалт

Монгол Улсад төрийн буюу албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын төрийн тэргүүнд болон гэргий /нөхөр/-д бие хамгаалагч үйлчилнэ. Бие хамгаалагчдыг Төрийн тусгай хамгаалалтын газартай урьдчилан зөвшилцөн зохицуулна.

41.6. Төрийн тэргүүн нарын уулзалт, хэлэлцээ, зоог

41.6.1. Ёслолын уулзалт

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг төрийн хүндэтгэлийн өргөөнд хүлээн авч, ёслолын уулзалт хийнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг төрийн хүндэтгэлийн өргөөний баруун талд угтан мэндчилж, баруун хойморын суудалд урина. Ерөнхийлөгчийн ёслолын уулзалтад оролцох монголын талын албаны хүмүүс гэрийн зүүн талаар, гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа хүмүүс баруун талаар зассан суудлуудад сууна. Ерөнхийлөгчийн ёслолын уулзалтад оролцогсдыг цай, цагаан идээ, төрөл бүрийн ундаагаар зочилно. Ёслолын уулзалт 15 минут хэртэй үргэлжилнэ. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

Ёслолын уулзалтад оролцогсод Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан гэрийн хойморoor нар зөв тойрч гарна.

41.6.2. Ганцаарчилсан уулзалт

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнтэй ганцаарчилсан уулзалт хийж болно. Ерөнхийлөгчийн ганцаарчилсан уулзалт хийх байрыг жич сонгож байх бөгөөд ганцаарчилсан уулзалтад хоёр талын орчуулагч, тэмдэглэл хөтлөх нийгмээд хүн байлцаж болно.

41.6.3. Бараалхах уулзалт

УИХ-ын дарга, Ерөнхий сайд гадаад улсын төрийн тэргүүний байрлаж буй Харш буюу буудалд очиж, түүнд бараалхаж болно. Бараалхалтад байлцах хүмүүсийг хоёр тал жич тохиролцоно.

41.6.4. Чуулганд үг хэлэх

Гадаад улсын төрийн тэргүүн УИХ-ын гишүүдийн өмнө үг хэлэх эсэхийг харилцааны түвшин, харилцан адил байх зарчмыг харгалзан тухай бүр жич шийдвэрлэнэ. Үг хэлэх тохиолдолд:

Гадаад улсын төрийн тэргүүн үг хэлэхээр танхимд орж ирэхэд УИХ-ын дарга, гишүүд суудлаа эзэлсэн байна. УИХ-ын чуулганы танхимын зүүн талд гадаад улсын төрийн тэргүүнд зориулан түшлэг бүхий зөөлөн сандал тавьсан байна. УИХ-ын дарга гадаад улсын төрийн тэргүүн УИХ-ын хуралдаанд оролцож байгааг УИХ-ын гишүүдэд мэдэгдэнэ. УИХ-ын дарга гадаад улсын төрийн тэргүүнийг үг хэлэхийг урина. Гадаад улсын төрийн тэргүүний хэлэх үгийг монгол хэлнээ хөрвүүлж УИХ-ын гишүүдэд урьдчилан тараасан байна.

Гадаад улсын төрийн тэргүүн үг хэлж дуусмагц УИХ-ын дарга гадаад улсын төрийн тэргүүнд сайн сайхныг ерөөнө. Төрийн тэргүүнийг танхимаас гарахад УИХ-ын гишүүд суудлаасаа босч алга ташиж үднэ.

41.6.5. Хэлэлцээ

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад орны төрийн тэргүүнтэй албан ёсны хэлэлцээ хийнэ. Хэлэлцээ Төрийн ордны хэлэлцээний танхимд явагдана. Хэлэлцээний ширээнд Монгол улсын болон тухайн улсын төрийн далбаа, хэлэлцээнд албан ёсоор оролцогсдын нэрс, микрофон, бичгийн хэргэсэл /дэвтэр, цаас, харандаа/ зэргийг тавина. Хэлэлцээний танхимын цонхон талд Монголын төлөөлөгчид, эсрэг талд нөгөө талын төлөөлөгчид сууна. Хоёр талын зөвлөх, мэргэжилтэн нар арын эгнээнд сууна. Хэлэлцээнд албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

Хэлэлцээний үеэр төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

41.6.6. Баримт бичигт гарын үсэг зурах

Гадаад улсын төрийн тэргүүний төрийн, албан ёсны болон ажлын айлчлалын үеэр баримт бичигт гарын үсэг зурах ёслол Төрийн ордны "Соёмбо" танхимд болно. Баримт бичигт гарын үсэг зурах ширээнээ баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын төрийн далбаа, гарын үсэг зурах үзэг, бэх дарагч, баримт бичгийг тавьсан байна.

Үсэг зурахын өмнө баримт бичгийн болон түүнд гарын үсэг зурах хүмүүсийн албан тушаал, овог нэрийг хэлж зарлана. Баримт бичигт гарын үсэг зурсан хүмүүс суудлаасаа босч баримт бичгүүдээ харилцан солилцоно. Баримт бичигт гарын үсэг зурж дуусмагц шампан дарс барина.

41.6.7. Хүндэтгэлийн зоог

Монгол улсад төрийн болон албан ёсны, ажлын айлчлал хийх гадаад улсын төрийн тэргүүн болон түүний гэргийг хүндэтгэж Монгол Улсын Ерөнхийлөгч /гэргийн хамт/ зоог барина. Зоогийн

байранд Монгол улс, тухайн улсын буюу тухайн төрийн тэргүүнд хамаарах далбааг мандуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүний суух ширээнд ууц тавина. Хүндэтгэлийн зоогт оролцох хүмүүсийн бүрэлдэхүүнийг хоёр орны харилцааны түвшин, дээд хэмжээний уулзалт хэлэлцээ, айлчлалын хөтөлбөрт тусгагдсан бусад арга хэмжээнд оролцсон байдлыг харгалзан Ёслолын хэлтэс жич тогтооно.

Зоогийн ширээнүүд дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад орны төрийн тэргүүний хэлэх үг, тэдгээрийн орчуулга, суух хүмүүсийн нэрс, зоогийн цэс, урлагийн тоглолтын хөтөлбөрийг тавина.

Хүндэтгэлийн зоогийн гол ширээнд суух хүмүүст тусгай ерөөнд архи, дарс, пиво, төрөл бүрийн ундаагаар апперитив барина. Зоогийн өмнө тухайн улсын болон Монгол улсын төрийн дуулал эгшиглэнэ. Төрийн дуулал эгшиглэж байхад бүх хүмүүс босож хүндэтгэнэ.

Хүндэтгэлийн зоогийн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүн харилцан үг хэлж хундага өргөнө. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

Зоогийн үеэр улаан, цагаан дарс, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

41.6.8. Бусад зүйл

Гадаад улсын төрийн тэргүүн Монгол улсад төрийн болон албан ёсны, ажлын айлчлал хийх хугацаанд түүнийг тухайн улсад суугаа Монгол улсын Элчин сайд, Ёслолын хэлтсийн дарга байнга дагаж үйлчилнэ. Төрийн тэргүүн гэргийтэй айлчлах тохиолдолд Элчин сайдын гэргий тухайн төрийн тэргүүний гэргийг дагаж үйлчилнэ.

Гадаад улсын төрийн тэргүүний гэргийд айлчлалын хугацаанд тусгай хөтөлбөр бэлтгэж үйлчилнэ.

Төрийн болон албан ёсны айлчлалын хувьд төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г оролцуулан 10 хүртэл хүний зардал /эочид буудал, хоол, машины зардлыг оролцуулан/-ыг монголын тал хариуцаж болно. Харилцан адил байх зарчим, тухайн цаг үеийн байдлаас хамаарч монголын талын зардал даах хүний тоо үүнээс цөөн байж болно.

Монгол улсад төрийн болон албан ёсны айлчлалаар анх удаа ирж байгаа гадаад улсын төрийн тэргүүн /гэргийн хамт/-д монгол үндэсний хувцас /дээл, малгай, бүс, гутал/ бүлэг өгнө. Албан ёсоор дагалдан яваа хүмүүст дэрсгалын зүйл өгөх эсэхийг харилцан адил байх зарчмыг харгалзан жич шийдэж байна.

Гадаад улсын төрийн тэргүүний айлчлалын хөтөлбөрийн хавтас нь монгол болон тухайн улсын төрийн далбааны зурагтай, монгол хэл, тухайн орны буюу харилцан тохиролцсон аль нэгэн хэл дээр хэвлэсэн байна.

41.6.9. Үдэх

Монгол улсад төрийн болон албан ёсны буюу ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал руу хөдлөхөөс

өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч /гэргийн хамт/ Гадаад улсын төрийн тэргүүний буусан буудалд очиж үдэх уулзалт хийнэ. Уулзалтад Гадаад харилцааны сайд, тухайн улсад суугаа Элчин сайд байлцана. Ерөнхийлөгч энэ уулзалтын төгсгөлд айлчлалын үеийн гэрэл зургийн цомгийг гадаад улсын төрийн тэргүүнд дурсгана. Ерөнхийлөгчийн гэргий гадаад улсын төрийн тэргүүний гэргийд амьд цэцгийн багтаа барина. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

Гадаад харилцааны сайд гадаад улсын төрийн тэргүүний хамт тусгай зориулалтын машинаар нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд ирнэ.

Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд хоёр улсын төрийн далбааг мандуулна. Нисэх онгоц /галт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна.

Гадаад орны төрийн тэргүүн /гэргий, нөхөр/-ийг нисэх онгоц /галт тэрэг/-ны буудлаас Гадаад харилцааны сайд (гэргий/нөхөр), тухайн улсад суугаа Элчин сайд, Ёслолын хэлтсийн дарга үдэж мордуулна.

42. Төрийн тэргүүний ажлын айлчлал

42.1. Угтах

Гадаад орны төрийн тэргүүн Монгол улсад ажлын айлчлалаар ирэхэд нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд Монгол улс, тухайн улсын төрийн буюу тухайн төрийн тэргүүний далбааг мандуулж, нисэх онгоц буюу галт тэрэгний шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна. Төрийн тэргүүнийг угтах ёслол тусгайлан үйлдэхгүй.

43. Төрийн тэргүүний хувийн айлчлал

43.1. Угтах

Гадаад улсын төрийн (гэргий/нөхөр) тэргүүн Монгол Улсад хувийн айлчлалаар ирэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /төрийн тэргүүн ЕТГ-ын дарга (гэргий/нөхөр), Ёслолын хэлтсийн дарга нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд угтана. Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал, байрлах өргөө, машинд далбаа мандуулахгүй. Угтах ёслол үйлдэхгүй. ЕТГ-ын дарга төрийн тэргүүнийг байрлах буудалд нь хүргэж ирнэ.

43.2. Ёслолын уулзалт, зоог

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол улсад хувийн айлчлалаар ирэх гадаад улсын төрийн тэргүүнийг энэ журмын 41.6.1-д заасны дагуу төрийн хүндэтгэлийн өргөөнд хүлээн авч уулзаж, өргөөндөө зоог барьж болно.

43.3. Үдэх

Монгол улсад хувийн айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүнийг Монгол Улсын ЕТГ-ын дарга зочид буудлаас нь авч нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд хүргэж ирнэ. Төрийн тэргүүнийг ЕТГ-ын дарга, Ёслолын хэлтсийн дарга үднэ.

43.4. Бусад зүйл

Гадаад улсын төрийн тэргүүнд айлчлалын хугацаанд тусгай зориулалтын машинаар үйлчилж, малгайн машин, бие хамгаалагч гаргаж ажиллуулна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын болон Ёслолын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнд хувийн бэлэг, дурсгалын зүйл өгч болно.

44. Парламентын даргын албан ёсны болон ажлын айлчлал

44.1. Угтах

Гадаад улсын Парламентын дарга Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирэхэд нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд Монгол Улс, тухайн улсын төрийн далбааг мандуулж нисэх онгоц /галт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвсэж угтана. Парламентын даргыг УИХ-ын дэд дарга (гэргий/нөхөр) тэргүүлж угтана. Угтах ёслол тусгайлан үйлдэхгүй.

44.2. Парламентын даргын уулзалт, хэлэлцээ, зоог

УИХ-ын дарга Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирэх гадаад улсын Парламентын даргатай ёслолын уулзалт, албан ёсны хэлэлцээ хийнэ. Уулзалт, хэлэлцээг албан ёсны орчуулагч хэлмэрчилнэ. Хэлэлцээний ширээнд Монгол Улсын болон тухайн улсын төрийн далбаа, хэлэлцээнд албан ёсоор оролцогсдын нэрс, бичгийн хэрэгсэл тавина.

Хэлэлцээний үеэр төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

44.3. Баримт бичигт гарын үсэг зурах

Гадаад улсын Парламентын даргын албан

ёсны болон ажлын айлчлалын үеэр баримт бичигт гарын үсэг зурах ёслол Төрийн ордны "Соёмбо" танхимд болно.

Баримт бичигт гарын үсэг зурах ширээнээ баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын төрийн далбаа, гарын үсэг зурах үзэг, бэх дарагч, баримт бичиг тавьсан байна. Үсэг зурахын өмнө баримт бичгийн болон үсэг зурах хүмүүсийн албан тушаал, овог нэрийг хэлж зарлана. Үсэг зурсан хүмүүс суудлаасаа босч баримт бичгүүдээ солилцож гар барина. Үсэг зурж дуусмагц шамлан дарс барина.

44.4. Хүндэтгэлийн зоог

Монгол Улсын Их Хурлын дарга (гэргий/нөхөр) албан ёсны болон ажлын айлчлалаар ирэх гадаад улсын Парламентын даргыг (гэргий/нөхөр) хүндэтгэж зоог барина. Зоогийн байранд Монгол Улс, тухайн улсын төрийн далбааг байрлуулна. Хүндэтгэлийн зоогт оролцох хүмүүсийн бүрэлдэхүүнийг хоёр орны харилцааны түвшин, уулзалт хэлэлцээ, айлчлалын хөтөлбөрт тусгагдсан бусад арга хэмжээнд оролцсон байдлыг харгалзан жич тогтооно.

Зоогийн ширээнүүд дээр хэлэх үг, тэдгээрийн орчуулга, суух хүмүүсийн нэрс, зоогийн цэс, урлагийн тоглолтын хөтөлбөрийг тавина. Апперитив барина. Зоогийн өмнө тухайн улс, Монгол улсын төрийн дууллыг эгшиглүүлнэ. Төрийн дуулал эгшиглэх үед бүх хүмүүс босож хүндэтгэнэ. Зоогийн үеэр улаан, цагаан дарс, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

44.5. Парламентын даргад үйлчлэх машин

Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Парламентын даргад тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Машины бэлэн байдал, найдвартай ажиллагааг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Төрийн тусгай хамгаалалтын газар шалгаж бэлтгэсэн байна. Магнайн машин гаргаж үйлчилнэ. Парламентын даргад үйлчлэх машин, ёслол, хамгаалалтын машинд холбооны аппарат хэрэгсэл суурилуулсан байна.

44.6. Парламентын даргын хувийн хамгаалалт

Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Парламентын даргад болон гэргий/нөхөр/-д бие хамгаалагч үйлчилнэ. Бие хамгаалагчийг Төрийн тусгай хамгаалалтын газартай урьдчилан зөвшилцөн зохицуулна.

44.7. Бусад зүйл

Гадаад улсын Парламентын дарга албан ёсны болон ажлын айлчлал хийх хугацаанд УИХ-ын

Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Ёслолын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ.

Албан ёсны айлчлалаар ирэх гадаад улсын Парламентын дарга, түүний гэргийг оролцуулан 8 хүртэл хүний зардлыг монголын тал хариуцаж болно. Харилцан адил байх зарчим, тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч монголын талын зардал даах хүний тоо үүнээс цөөн байж болно.

Монгол Улсад албан ёсны буюу ажлын айлчлалаар ирэх гадаад улсын Парламентын дарга (гэргий/нөхөр)-д бэлэг, дурсгалын зүйл өгнө.

Гадаад улсын Парламентын даргын албан ёсны болон ажлын айлчлалын хөтөлбөрийн хавтас нь Монгол улс, тухайн улсын төрийн далбааны зурагтай, монгол хэл, тухайн орны буюу харилцан тохиролцсон аль нэгэн хэлээр хэвлэгдсэн байна.

44.8. Үдэх

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын Парламентын дарга (гэргий/нөхөр) нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал руу хөдлөхөөс өмнө УИХ-ын дарга (гэргий/нөхөр) гадаад улсын Парламентын даргын (гэргий/нөхөр) буусан буудалд очиж үдэж уулзана. Уулзалтад УИХ-ын дэд дарга (гэргий/нөхөр) байлцана. УИХ-ын дарга гадаад улсын Парламентын даргад айлчлалын үеийн гэрэл зургийн цомог дурсгана. УИХ-ын даргын гэргий /нөхөр/ гадаад улсын Парламентын даргын гэргий /нөхөр/-д амьд цэцгийн баглаа барина.

УИХ-ын дэд дарга гадаад орны Парламентын даргыг нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд хүргэж ирнэ.

Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд Монгол улс, тухайн улсын төрийн далбааг мандуулж нисэх онгоц /галт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна. Парламентын даргыг нисэх онгоц /галт тэрэг/-ны буудлаас УИХ-ын дэд дарга (гэргий/нөхөр), Ёслолын хэлтсийн дарга үдэж мордуулна.

45. Гадаад улсын парламентын даргын хувийн айлчлал

Гадаад улсын Парламентын дарга (гэргий/нөхөр) Монгол Улсад хувийн айлчлалаар ирэхэд УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга (гэргий/нөхөр), Ёслолын хэлтсийн дарга утгана. Ерөнхий нарийн бичгийн дарга гадаад улсын Парламентын даргыг байрлах буудалд нь хүргэж ирнэ.

45.1. Ёслолын уулзалт, зоог

УИХ-ын дарга (гэргий/нөхөр) Монгол Улсад хувийн айлчлалаар ирэх гадаад улсын Парламентын даргыг (гэргий/нөхөр) хүлээн авч ёслолын уулзалт



хийж, зоог барьж болно.

45.2. Бусад зүйл

Гадаад улсын Парламентын даргын хувийн айлчлалын хугацаанд түүнд тусгай зориулалтын машин, бие хамгаалагч гаргаж үйлчилнэ. УИХ-ын Тамгын газрын болон Еслолын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ.

УИХ-ын даргаас гадаад улсын Парламентын даргад хувийн болэг өгч болно. Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал, өргөө, машинд төрийн далбаа мандуулахгүй. Парламентын даргыг УИХ-ын ТГ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга буудлаас нь авч нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд хүргэж ирнэ. Угтсан хүмүүс үдэж гаргана.

46. Гадаад улсын засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлал

46.1. Угтах

а) Монгол улсад албан ёсны айлчлалаар ирэх гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд угтахад энэ журмын 41.1-ийн "а"-г баримтална;

б) "Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа ... улсын... Эрхэмсэг ноён (хатагтай) ... Танд тавтай саатан морилохыг ерөөе" гэсэн үг бүхий самбарыг Сүхбаатарын талбайн өмнөх цэцэрлэгт монгол, тухайн улсын буюу тохиролцсон аль нэг хэлээр бичиж байрлуулна;

в) гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй хийх албан ёсны яриа хэлэлцээнд оролцох Монгол улсын Засгийн газрын нэг гишүүн /хойшид Засгийн газрын гишүүн гэнэ/ (гэргий/нөхөр) онгоц /галт тэрэг/-ны буудалд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг угтана.

46.2. Сүхбаатарын талбайд угтах

46.2.1. Монгол улсад албан ёсны айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг угтах ёслол Сүхбаатарын талбайд болно. Талбайн төв хэсэг дэх тугны ишний баруун талынхад тухайн улсын, зүүн талынхад Монгол улсын төрийн далбаа, тэдгээрийн дунд Улаанбаатар хотын далбааг мандуулна. Төрийн далбаануудын баруун талд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим, төрийн ёслолын хүндэт харуул /48 цэрэг/ зүүн тийш харж жагсана. Хүндэт харуулын эхэнд хүндэт харуулын туг байна.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг угтах Монголын талын албаны хүмүүс хүндэт харуулын зүүн гар талд урагш харан баруун гар талаас ёслолын ахлалын дарааллаар зогсоно.

Мандуулсан далбаануудын зүүн талд хоёр улсын Засгийн газрын тэргүүнд зориулж 3x2 м хэмжээтэй тавцан тусгайлан зассан байна. Уг тавцан зүүн, баруун талдаа нээлттэй байх бөгөөд бусад шонгуудыг хооронд нь улаан туузаар холбосон байна. Шонгуудын өндөр нь 70 см байна.

Монгол улсын Ерөнхий сайд, түүний гэргий гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй уулзаж гар барих газар хивс дэвссэн байна. Тэр цэгээс эхлэн ёслол үйлдэх бүх замын дагуу улаан өнгөтэй гудаслаг хивс үргэлжлүүлэн дэвсэнэ.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүний суусан машин Сүхбаатарын талбай руу гарч ирэхэд үлээвэр хөгжимд угтах марш эгшиглэнэ. Зочны машин заасан газарт ирж зогсоход төрийн ордны хамгаалалтын албаны хоёр офицер Засгийн газрын тэргүүний (гэргий/нөхөр) талын хаалгыг нээн өгч ёсолно. Засгийн газрын тэргүүн (гэргий /нөхөр), Монгол улсын Засгийн газрын гишүүн (гэргий/нөхөр) угтахаар ирсэн Монгол Улсын Ерөнхий сайдын зүг явахад Монгол Улсын Ерөнхий сайд (гэргий/нөхөр) мөн тэдний зүг алхаж хивсний голд уулзан гар барьж мэндэлнэ. Энэ үед гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/-д үндэсний хувцастай эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд амьд цэцгийн баглаа барина. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч, тусгайлан зассан тавцанд гарахад хүндэт харуулын захирал угтан ирж "Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа ... улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён /хатагтай/... Таныг хүндэтгэн Монгол улсын төрийн хүндэт харуул жагссан. Хүндэт харуулын захирал..." гэж цэргийн цол, овог, нэрээ хэлж айлтгал өргөнө. Хүндэт харуулын захирал байрандаа баруун гар тийш эргэж Монгол улсын Ерөнхий сайд болон гадаад улсын Засгийн газрын тэргүүн рүү хараа шилжүүлэн зогсоход хөгжим эхлээд тухайн улсын төрийн дуулал, дараа нь Монгол улсын төрийн дуулал тоглоно. Энэ үед Ерөнхий сайдын гэргий /нөхөр/ гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гартаа авч, тавцангийн зүүн талд хоёр метр зайтай зогсоно. Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг угтсан Монгол улсын Засгийн газрын гишүүн (гэргий/нөхөр) хоёр Засгийн газрын тэргүүний гэргийн /нөхөр/ ард зогсоно.

Төрийн дуулал эгшиглэж дуусахад Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар тавцангаас бууж хүндэт харуулын зүг явна. Хүндэт харуулын захирал гурван алхмын зайд дагалдан явна. Хоёр орны Засгийн газрын тэргүүн хүндэт харуулын жагсаалын эхэнд залсан хүндэт харуулын туганд толгой мэхийн хүндэтгэл илэрхийлнэ. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг эндээс эхлэн зүүн гартаа авч, цааш яван жагсаалын дунд хэрд очоод цэргүүд рүү харж түр зогсоно. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн /сайн



байцгаана уу” гэж мэндэлнэ. Хүндэт харуулын цэргүүд “ амрыг эрье” гэж хариу мэндэлнэ.

Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хүндэт харуулын өмнүүр явж өнгөрөөд монголын талын албаны хүмүүсийн зүг эргэн явна. Хүндэт харуулын захирал дороо эргэж хүндэт харуул тийш алхана. Энэ үед Ерөнхий сайдын гэргий /нөхөр/ , гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий / нөхөр/, тэднийг угтсан Монгол улсын Засгийн газрын гишүүн түүний гэргий /нөхөр/ нар тэдний араас дагалдан явж, утгасадтай мэндчилнэ.

Ёслолын хэлтсийн дарга монголын талын албаны хүмүүсийг танилцуулна.

Монголын талын албаны хүмүүсээс доош гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг дагалдан яваа төлөөлөгчид баруун гар талаас ёслолын ахлалаар эгнэн зогсоно. Нөгөө талын ёслолын хэлтсийн дарга /ажилтан/ өөрийн талын төлөөлөгчдийг Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулна.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг дагалдан яваа төлөөлөгчдийн доод талд тухайн улсаас Монгол улсад суугаа ДТГ-ын гишүүд байх бөгөөд тэднийг тус ДТГ-ын тэргүүн танилцуулна. Үүгээр угтах ёслолын ажиллагаа өндөрлөнө.

46.3. Засгийн газрын тэргүүний байрлах байр

Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг хаана байрлуулахыг нөгөө талтай урьдчилан тохирно.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүний байрлах Харш буюу зочид буудлын өмнө талд тухайн улсын төрийн далбааг мандуулна.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд угтсан албан тушаалтан /Засгийн газрын гишүүн/ Харш буюу зочид буудалд хүргэж ирнэ. Харш буюу зочид буудлын дарга хүндэт зочныг анх очиход угтаж, явахад нь үдэж явуулна.

46.4. Засгийн газрын тэргүүнд үйлчлэх машин

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирэх гадаад улсын Засгийн газрын тэргүүнд болон түүний гэргийд тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Тусгай зориулалтын машины бэлэн байдал, найдвартай ажиллагааг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Төрийн тусгай хамгаалалтын газар шалгаж бэлтгэсэн байна. Магнайн машин гаргаж үйлчилнэ. Тусгай зориулалтын машин, ёслол, хамгаалалтын машинд холбооны аппарат хэрэгсэл суурилуулсан байна.

46.5. Засгийн газрын тэргүүний хувийн хамгаалалт

Монгол улсад албан ёсны болон ажлын

айлчлалаар ирэх гадаад улсын Засгийн газрын тэргүүнд болон түүний гэргий /нөхөр/-д бие хамгаалагч үйлчилнэ. Бие хамгаалагчийг Ёслолын хэлтэс Төрийн тусгай хамгаалалтын газартай урьдчилан зөвшилцөн зохицуулна.

46.6. Уулзалт, хэлэлцээ, зоог

46.6.1. Ёслолын уулзалт

Монгол Улсын Ерөнхий сайд Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад орны Засгийн газрын тэргүүнийг хүлээн авч ёслолын уулзалт хийнэ. Уулзалтын үеэр цай, цагаан идээ, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

46.6.2. Ганцаарчилсан уулзалт

Монгол Улсын Ерөнхий сайд Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй ганцаарчилсан уулзалт хийж болно. Ёслолын болон ганцаарчилсан уулзалтад албан ёсны хүмүүсээс гадна орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

46.6.3. Бараалхах уулзалт

а) Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхуулна;

б) Монгол улсын Засгийн газрын гишүүн, Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнд бараалхаж болно. Бараалхах уулзалтыг түүний байрласан зочид буудал буюу Харшид очиж хийнэ.

46.6.4. Хэлэлцээ

Монгол Улсын Ерөнхий сайд Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй албан ёсны хэлэлцээ хийнэ. Хэлэлцээний ширээнд Монгол улс, тухайн улсын төрийн далбаа, хэлэлцээнд албан ёсоор оролцогсдын нэрс, бичгийн хэрэгсэл тавина. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтлөх хүмүүс байна.

46.6.5. Баримт бичигт гарын үсэг зурах

Гадаад улсын Засгийн газрын тэргүүний албан ёсны болон ажлын айлчлалын үеэр баримт бичигт гарын үсэг зурах ёслол Төрийн ордны “Соёмбо” танхимд болно. Баримт бичигт гарын үсэг зурах ширээнээ баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын төрийн далбаа, гарын үсэг зурах үзэг, бэх дарагч, баримт бичгүүдийг тавьсан байна.

Үсэг зурахын өмнө баримт бичгийн болон үсэг зурах хүмүүсийн албан тушаал, овог, нэрийг



хэлж зарлана. Үсэг зурсан хүмүүс суудлаасаа босч баримт бичгүүдээ солилцож гар барина. Үсэг зурж дуусмагц ёслолд оролцогсод шампан дарс барина.

46.6.6. Хүндэтгэлийн зоог

Монгол Улсын Ерөнхий сайд /гэргийн хамт/ Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүн болон түүний гэргийг хүндэтгэж зоог барина. Зоогийн байранд тухайн улсын болон Монгол улсын төрийн далбааг байрлуулна. Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүний суух ширээнд ууц тавина. Хүндэтгэлийн зоогт оролцох хүмүүсийн бүрэлдэхүүнийг хоёр орны харилцааны түвшин, уулзалт хэлэлцээ, айлчлалын хөтөлбөрт тусгагдсан бусад арга хэмжээнд оролцсон байдлыг харгалзан жич тогтооно.

Зоогийн ширээнүүд дээр Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад орны Засгийн газрын тэргүүний хэлэх үг, тэдгээрийн орчуулга, суух хүмүүсийн нэрс, зоогийн цэс, хүндэтгэлийн зоогийн үеэр үзүүлэх урлагийн тоглолтын хөтөлбөрийг тавина.

Хүндэтгэлийн зоогийн гол ширээнд суух хүмүүст тусгай өрөөнд архи, дарс, пиво, төрөл бүрийн ундаагаар апперитив барина. Апперитив арван таван минут орчим үргэлжилнэ. Зоогийн өмнө тухайн улсын болон Монгол Улсын төрийн дуулал эгшиглэнэ. Төрийн дуулал эгшиглэж байхад бүх хүмүүс босож хүндэтгэнэ. Хүндэтгэлийн зоогийн үеэр Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн харилцан үг хэлж хундага өргөнө.

Зоогийн үеэр улаан, цагаан дарс, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

46.7. Бусад зүйл

Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийхэд түүнийг тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайд, Ёслолын хэлтсийн дарга дагаж үйлчилнэ.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргийд айлчлалын үед тусгай хөтөлбөр бэлтгэж үйлчилнэ.

Монгол улсад албан ёсны айлчлал хийх

гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргийг оролцуулан 8 хүртэл хүний зардал /байр, хоол, машины зардлыг оролцуулан/-ыг монголын тал хариуцаж болно. Харилцан адил байх зарчим, тухайн цаг үеийн байдлаас хамаарч монголын талын зардал даах хүний тоо үүнээс цөөн байж болно.

Монгол улсад албан ёсны айлчлалаар анх удаа хүрэлцэн ирж байгаа гадаад улсын Засгийн газрын тэргүүн /гэргийн хамт/-д монгол үндэсний хувцас /дээл, малгай, бүс, гутал/ бэлэглэнэ. Албан ёсоор дагалдан яваа хүмүүст дурсгалын зүйл өгөх эсэхийг харилцан адил байх зарчмыг харгалзан жич шийдэж байна.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүний айлчлалын хөтөлбөрийн хавтас нь монгол болон тухайн улсын төрийн далбааны зурагтай, монгол хэл, тухайн орны буюу харилцан тохиролцсон аль нэгэн хэл дээр хэвлэсэн байна.

46.8. Үдэх

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийсэн гадаад улсын Засгийн газрын тэргүүн нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал руу хөдлөхөөс өмнө Монгол Улсын Ерөнхий сайд /гэргийн хамт/ гадаад улсын Засгийн газрын тэргүүн /гэргийн хамт/-ий буусан буудалд очиж үдэж уулзана. Уулзалтад Засгийн газрын тэргүүнийг угтсан Монгол улсын Засгийн газрын гишүүн, тухайн улсад суугаа Элчин сайд байлцана. Ерөнхий сайд энэ уулзалтын үеэр айлчлалын үеийн гэрэл зургийн цомгийг гадаад улсын Засгийн газрын тэргүүнд дурсгана. Ерөнхий сайдын гэргий гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргийд амьд цэцгийн баглаа барина.

Засгийн газрын тэргүүнийг анх угтсан Монгол улсын Засгийн газрын гишүүн зочны хамт нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд ирнэ. Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд хоёр улсын төрийн далбааг мандуулж, нисэх онгоц /галт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна.

Гадаад орны Засгийн газрын тэргүүн /гэргий, нөхөр/-ийг нисэх онгоц /галт тэрэг/-ны буудлаас Монгол улсын Засгийн газрын гишүүн /гэргий/, тухайн улсад суугаа Элчин сайд, ГХЯ-ны Ёслолын хэлтсийн дарга үдэж мордуулна.

(Үргэлжлэл бий)

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ДАМПУУРЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Дампуурлын тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4

дэх заалт, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалтуудыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Дампуурлын тухай хуулийн /цаашид хууль гэх/ 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан "... өөрийн хөрөнгийн" гэдэгт шүүх төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгж, байгууллагын хамгийн сүүлд татварын байгууллагад гаргасан тайлан тэнцэл, түүнийг баталгаажуулсан шинжилгээ, дүгнэлтийг үндэслэн үндсэн ба эргэлтийн нийт хөрөнгөөс бусдад төлөх өр төлбөрийн хэмжээг хассан зөрүүгээр хариуцагчийн өөрийн хөрөнгийн хэмжээг тогтоосныг хамааруулж ойлгоно.

Хариуцагч аж ахуйн нэгж байгууллага тайлан тэнцэлдээ бусдад төлөх өр төлбөр, авах авлагын хэмжээг бүрэн тусгаагүй эсхүл бууруулсан буюу нэмэгдүүлсэн тохиолдолд шүүх дээрх тусгагдаагүй үнийн дүнг нийт өр төлбөр, авлагын хэмжээнд оруулан тооцвол зохино. Энэхүү ойлголтыг мөн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хариуцагчийн төлбөрийн чадвартай болох эсэхийг тооцоход нэгэн адил хамааруулна.

Мөн зүйл хэсгийн "... төлбөрийн чадваргүйд тооцно" гэдэгт хариуцагч банкн дахь харилцах болон тооцооны хадгаламжийн дан түүнчлэн өөрийн кассанд бэлэн мөнгөний хүрэлцээгүйгээс нэхэмжлэгчээс нийлүүлсэн буюу худалсан бараа, бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үзүүлдсэн үйлчилгээний үнэ хөлс, мөн банк болон бусдаас олгосон зээлийг төлөх зэрэг зээл тооцооны харилцаанд хүлээсэн, өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хуьтай тэнцэх үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаандаа биелүүлж чадэхгүй байгааг ойлгоно.

2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дахь хэсгийн "... Зохигчдын өр төлбөрийн асуудлыг зохих хуулийн дагуу хянан шийдвэрлэнэ" гэдэгт Шүүх энэ хуулийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу хариуцагчийг төлбөрийн чадвартай гэж тогтоосон тохиолдолд зохигчдын өр төлбөрийн нэхэмжлэлийг ИХШХШ тухай хуульд заасан ердийн журмаар шийдвэрлэнэ. Ингэхдээ хариуцагчийг төлбөрийн чадвартай болохыг тогтоож, хэргийг хэрэгсэхгүй болгох болон нэхэмжлэлийг шүүх ердийн журмаар шийдвэрлэх асуудлуудыг нэг хуралдаанаар шийдвэрлэх болно.

3. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 26 дугаар 26.3 дахь хэсгүүдэд заасан "хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ" гэдгийг шүүх хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосноос хойш энэ хуульд заасан хугацааны дотор тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хүрээг харгалзан төв, орон нутгийн өдөр тутмын сонин, хэвлэл, радио, телевиз буюу бусад аргаар зарлан мэдэгдэхийг ойлговол зохино.

4. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн "... хэрэг гүйцэтгэгчийг түр томилж болно" гэдэгт шүүгч дампуурлын хэрэг үүсгэхдээ

шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар хариуцагчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох, хөрөнгийг хууль бусаар үрэгдүүлэхгүй байлгах зорилгоор хэрэг гүйцэтгэгчийг шүүгчийн захирамж буюу шүүхийн тогтоолоор түр томилж болох бөгөөд ингэхдээ мөн хуулийн 11.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хувь хүн эсхүл хуулийн этгээдийг томилно.

Шүүх дампуурлын хэрэг үүсгэх болон хэрэг гүйцэтгэгчийг түр томилох асуудлыг нэг захирамж, шүүхийн тогтоолоор шийдвэрлэх болно.

5. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгүүдэд заасан "... оролцогч этгээдүүд" гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч нэхэмжлэгчдийн зөвлөл, нэхэмжлэгчдийн хурал хэрэв хариуцагч нь төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар байгаа бол Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч зэрэг эрх бүхий этгээдийг багтаан ойлгоно.

Мөн зүйлийн 6.3 дахь хэсгийн "... түр зогсох" гэдэгт Дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх явцад гаргасан шүүгчийн захирамж, тогтоол мөн хуулийн 6.1 дэх хэсэгт заасан гомдлыг хянан шийдвэрлэх хугацааг тухайн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэх хугацаанд оруулж тооцохгүй байхыг ойлгоно.

6. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын "... санхүүгийн тайлан тэнцэл" гэдэгт Төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн буюу эргэлтийн хөрөнгө түүний эх үүсвэр, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн /орлого, үр дүнгийн болон үлдэгдэл, мөн хуримтлалын балансууд/, мөнгөн хөрөнгийн хөдөлөлийг харуулсан баримтууд түүнчлэн тухайн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүнд хийсэн шинжилгээ, дүгнэлт зэргийг хамруулан ойлгоно.

Мөн зүйлийн "... сүүлийн 3 жил" гэдгийг хуанлийн тооллоор бус харин тухайн аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байсан үеийн сүүлийн 3 жилийг хамруулан ойлговол зохино.

7. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын "... итгэмжлэн өмчилсэн эд хөрөнгө" гэдэгт өмчлөгчөөс хууль буюу гэрээгээр тодорхойлон олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх эдэлж буй хуулийн этгээдийн эд хөрөнгийг ойлгоно.

8. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "... нэхэмжлэгч бүр бүх нэхэмжлэлийн нийт шаардлагын дүнд өөрийн нэхэмжлэлийн шаардлагын эзлэх хувьтай тэнцүү саналын эрхтэй оролцоно" гэдгийг Нэхэмжлэгчдийн хурал болох тухайн үеийн нэхэмжлэлийн шаардлагын нийт үнийн



дүнд нэхэмжлэгч нь өөрийн нэхэмжлэлийн шаардлагын зэлэх хувьтай тэнцүү саналын эрхтэй оролцоно гэж ойлговол зохино. Өөрөөр хэлбэл дээрх саналын эрхийг тооцоодоо хэрэг гүйцэтгэгч энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан дагуу дүгнэлт гаргахаас өмнөх хугацаанд энэ тайлбарын заалтад заасан нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг, харин хэрэг гүйцэтгэгч дүгнэлт гаргасан тохиолдолд уул дүгнэлтийн нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг тус тус баримтална.

9. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын "... Шүүхээр шийдвэрлүүлэх асуудлаар шүүхэд хандах" гэдгийг Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь илтэд хуульд нийцэхгүй байгаа эсхүл хариуцагч уул шаардалгыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй маргаантай байгаа эсхүл уг хуулиар шүүхэд харьяалуулсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгч нь шүүхэд ердийн журмаар нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлбэл зохино.

Түүнчлэн хэрэг гүйцэтгэгч нь мөн зүйлийн 12.1.6-д зааснаар нэхэмжлэгчдийн хурлаар дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шийдвэрлэсэн нэхэмжлэлийн асуудлаар мөн дээрх журмаар шүүхэд нэхэмжлэл гаргана.

10. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7.22 дугаар зүйлийн 2 дахь хэсгүүдэд заасан "... тусгай данс" гэдэгт хэрэг гүйцэтгэгч нь шүүх дампуурлын хэрэг үүсгэснээс хойшхи хугацаанд хариуцагчийн орлого, зарлага болон төлбөр тооцооны бусад харилцааг хэвийн явуулах, тухайн хариуцагчийн хөрөнгийг төвлөрүүлэх зорилгоор түүний нэр дээр банкинд шинээр харилцах данс нээнэ гэж ойлговол зохино.

11. 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан "... хуурч мэхлэх" гэдэгт Хэрэг гүйцэтгэгч хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх явцдаа хариуцагчийг төөрөлдүүлэх зорилгоор үгээр буюу үйлдлээр үнэн байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, хуурамч баримт ашиглах зэргээр хариуцагч, нэхэмжлэгч нарын төлбөрийн хэмжээг зохиомлоор ихэсгэх, багасгах, өсгөх зэргээр өөрчлөн тэдгээрт санаатэйгээр хохирол учруулсан байхыг ойлгоно.

Мөн зүйлийн "... хайхрамжгүй хандах" гэдгийг хэрэг гүйцэтгэгч нь мөн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар өөрт олгогдсон эрх мэдлийн хүрээнд

багтах үйл ажиллагааг хийгээгүй буюу зохих ёсоор хийлгээгүй төдийгүй өөриймсөг хандаагүйн улмаас зохигчдод хохирол учруулсныг ойлговол зохино.

12. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн "... Засгийн газар, иргэдийн төлөөлөгчдийн хурал төлбөрийн чадваргүй болсон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өр төлбөрийг төлөх тухай баталгаа" гэдэгт тухайн төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгж байгууллагыг хэвийн үйл ажиллагаатай болгоход бодит дэмжлэг үзүүлэх, өөрөөр хэлбэл санхүүгийн /мөнгөн хөрөнгийн/ туслалцааг үзүүлэх талаар бичгээр гаргасан хүсэлтийг шүүхэд ирүүлэхийг ойлгоно.

13. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "... хамгийн өндөр үнэд хүргэх" гэдгийг Хэрэг гүйцэтгэгч нь тухайн эд хөрөнгийг худалдах үеийн зах зээлийн дундаж үнийг санхүүгийн болон үнэлгээний байгууллагаар албан ёсоор тогтоолгож, уулс үнээс доошгүй эсхүл Иргэний хуулийн 162 дугаар зүйлд заасан дагуу эд хөрөнгийг үнэ хяалцуулах дуудлага худалдаагаар зарж борлуулахад ялсан этгээдийн санал болгосон үнэ зэргийг хамруулан ойлговол зохино.

Харин үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн тухай болон Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулиудад заасан журмыг баримтлан худалдаж борлуулсан үнийг ойлгоно.

14. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын "... үүсгэн байгуулах баримт бичиг" гэдэгт хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд тухайн хариуцагчийг анх байгуулах тухай шийдвэр, түүнчлэн эрх бүхий этгээдийн шийдвэр, түүний дүрэм, гэрээ зэргийг хамруулна.

Тухайлбал компани, хоршооны дүрэм, нөхөрлөлийн гэрээ болон тусгайлан эрх олгосон Засгийн газар болон орон нутгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэр зэргийг хамааруулна.

15. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн "хамгийн тохиромжгүй нөхцөлд хамаарч байгаа" гэдэгт дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөний дагуу тухайн нэхэмжлэгчид онгодох төлбөрийн хэмжээ нь түүний нэхэмжлэлийн нийт дүнд бусдаасаа хамгийн бага хувь эзлэхийг ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ч. ГАНБАТ

ШҮҮГЧ

Д. ТУНГАЛАГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

■ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

■ 329487